




ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ЖАЙКА ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСУУДАЛ: БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА 2019

МЭДЭЭЛЛИЙН ЛАВЛАХ





ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ЖАЙКА ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа

Мэдээллийн лавлах

Улаанбаатар хот
2019 он

Зургийн нэр : Хүүхдэд ээлтэй авто зам

Зураач : А.Алтангоо (63-р тусгай сургууль)

Зургийн эх сурвалж : “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” (START)

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО МЭДЭЭЛЭЛ

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ТАВДУГААР БҮЛЭГ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ЗУРГААДУГААР БҮЛЭГ: ЭРҮҮЛ МЭНД

ДОЛООДУГААР БҮЛЭГ: БОЛОВСРОЛ

НАЙМДУГААР БҮЛЭГ: ХҮРТЭЭМЖ

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: ЯАМДЫН ДЭРГЭДЭХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ОНЦЛОХ АЖЛУУД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	
Барилга, хот байгуулалтын яам	
Батлан хамгаалах яам	
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	
Гадаад харилцааны яам	
Зам, тээврийн хөгжлийн яам	
Сангийн яам	
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	
Хууль зүй, дотоод хэргийн яам	
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	
Эрүүл мэндийн яам	
Эрчим хүчний яам	
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар.....	

АРАВДУГААР БҮЛЭГ: ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага.....
 - Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)
 - Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл

- Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээ, боловсролыг дэмжих болон асран хамгаалагчдыг хөгжүүлэх төсөл
2. Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”
 3. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв төсөл”

ХАВСРАЛТ

Хавсралт 1 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он

Хавсралт 2- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Хавсралт 3 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн тоо, насаар, төрлөөр, бэрхшээлийн хэлбэрээр

Хавсралт 4 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгосон тусламж, хөнгөлөлтөд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө, 2018 он

Хавсралт 5 - Монгол Улсын хөгжлийн бэрхшээлийн салбарт хамтран ажилладаг байгууллагуудын мэдээлэл

Хавсралт 6 - Монгол Улсын хөгжлийн бэрхшээлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын мэдээлэл

ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Япон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд **“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа-2017”** мэдээллийн лавлах номыг монгол хэлээр боловсруулан гаргаж, англи болон япон хэл дээр орчуулан цахим хэлбэрээр үндэсний хэмжээнд түгээн олон нийтэд хүргэлээ.



Тус мэдээллийн лавлах ном нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, холбогдох бусад байгууллагуудын удирдлага, ажилтан албан хаагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэрэгцээт мэдээллээр нь хангаж, үйл ажиллагаандаа байнга ашигладаг ном болсон.

Энэ жилийн хувьд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгуулагдаж, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн үйл ажиллагаа эхэлж, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төв”-ийн барилга ашиглалтад орсон зэрэг олон чухал үйл явдал болж өрнөлөө.

Тус номонд эдгээр үйл ажиллагааны талаарх мэдээллийг тусгахын зэрэгцээ бүх яамны болон зарим агентлагийн дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бодлого, үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэн гаргаж байгаагаараа онцлог болж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Япон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хамт олонд энэхүү номыг боловсруулах, хэвлүүлэхэд бүх л талын дэмжлэг үзүүлсэнд талархсанаа илэрхийлье.

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга,
“Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн
оролцоог дэмжих төсөл”-ийн зохицуулах зөвлөлийн дарга
С.Тунгалагтамир*

ӨМНӨХ ҮГ



2018 оны 03 дугаар сард хэвлэгдэн гарсан монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого, үйл ажиллагааны талаарх анхдагч мэдээллийн лавлах “Цагаан ном” 2019 онд дахин хэвлэгдэж байгаа явдал нь тэмдэглүүштэй явдал болж байна.

Тус “Цагаан ном”-ын үндсэн зорилго нь монголын Засгийн газраас хэрэгжүүлж буй хөгжлийн бэрхшээлийн салбартай холбоотой бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг нэгтгэн, ард иргэдэд мэдээлэх явдал юм. Эхний дугаарын

“Цагаан ном” 800 хувь хэвлэгдэн тараагдаж, төр болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд олон талаас ашиглагдаж байгаад тун баяртай байна.

Хөгжлийн бэрхшээлийн асуудлууд нь нийгмийн бүхий л салбаруудтай холбоотой байдаг. Тиймээс зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам төдийгүй холбогдох яам, газруудын дэд зөвлөлийн үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлийн талаарх бодлогыг оруулах нь нэн чухал юм. Ялангуяа энэ удаагийн “Цагаан ном”-д салбар яамдын дэд зөвлөлүүдийн 2018 оны үйл ажиллагааны талаар түлхүү оруулахыг зорилоо.

Мөн мэдээллийг хүртээмжтэй байлгахын тулд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудас дээр байршуулах ба олон улсад монголын хөгжлийн бэрхшээлийн салбарыг сурталчлах зорилгоор англи болон япон хэл дээр хэвлэн гаргаж байгаа билээ.

“Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл” нь “Цагаан ном”-ын боловсруулалт болон хэвлэлтэн дээр хамтарч ажиллах болсондоо баяртай байна. Тус “Цагаан ном”-ыг цаашид тасралтгүй бэлтгэн гаргаж, шинэ мэдээллүүдийг ард иргэдэд хүргэж байх нь чухал бөгөөд 2 дахь дугаар нь өмнөх дугаарын адил олон байгууллага, хувь хүмүүст ашиглагдана гэдэгт итгэлтэй байна.

*“Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй
иргэдийн нийгмийн оролцоог дэмжих
төсөл”*

Ахлах зөвлөх Чибя Хисао

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгуулагдлаа.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 61 дүгээр чуулганаар баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколд Монгол Улс 2008 онд нэгдэн орж, уг конвенцийн үзэл баримтлалд тулгуурлан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг УИХ-аас 2016 онд баталсан.

Тус хуулийн 40 дүгээр зүйлд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд ажиллах хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бий болгохоор хуульчилсан.

Иймд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх замаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг УИХ-ын 2018 оны 56, Засгийн газрын 2018 оны 250 дугаар тогтоолоор байгуулсан.

Дээрх УИХ, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/233 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрийг баталсан билээ.

Агентлаг нь Тамгын, Бодлогын хэрэгжилтийн, Хөгжил нийгмийн оролцооны, Хяналт-шинжилгээ үнэлгээний гэсэн 4 газар, нийт 35 хүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Тамгын газар

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөв санхүү хөрөнгө оруулалтын үр ашгийн дээшлүүлэх, олон нийттэй харилцах үйл ажиллагааг өргөжүүлэх чиг үүрэгтэй |



Бодлогын хэрэгжилтийн газар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээрх стратеги, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах замаар тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, бие даан амьдрах, хөгжих боломжийг бүрдүүлэх чиг үүрэгтэй.



Хөгжил, нийгмийн оролцооны газар

Төр, төрийн бус, олон улсын байгууллагууд, орон нутаг болон бусад холбогдох салбар хоорондын уялдаа, холбоог хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоог хангах, хөгжлийг дэмжих, чадавхижуулах, энэ чиглэлээр статистик, судалгаа, сургалт, нөлөөллийн арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллана.



Хяналт, шинжилгээ үнэлгээний газар

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх, дотоод хяналт, шалгалт, аудитыг зохих журмын дагуу зохион байгуулах, холбогдох байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллана.



Агентлагийн орон нутаг дахь чиг үүргийг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хариуцан ажиллаж байна.

Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл” хэрэгжиж эхэллээ.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг Азийн хөгжлийн банкны Тусгай сангийн 25 сая ам.долларын 25 жилийн хугацаатай, 5 жилийн үндсэн зээлээс чөлөөлөгдөх хугацаатай, уг чөлөөлөгдөх хугацаанд болон түүнээс хойш жилийн зээлийн хүү 2% байх хөнгөлттэй зээл, Японы ядуурлыг бууруулах сангаас 2 сая ам. долларын буцалтгүй тусламжийг Азийн хөгжлийн банкаар дамжуулан олгоно.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 1.87 сая доллартай тэнцэх хэмжээний биет хувь нэмрийг барилгын ажлууд, тоног хэрэгсэлд үзүүлэх татварын чөлөөлөлт, 0,07 сая ам. долларын дүнтэй дүйцэх Төслийн хэрэгжүүлэх нэгжийн оффисоор хангахаар тусгасан.

Тус төслийг хэрэгжүүлэх зээлийн гэрээ, хэлэлцээрт 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр гарын үсэг зурсан.

Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр уг төслийг баталж, төслийн нэгж, Удирдах хороог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар байгуулаад байна.

Энэхүү төслийн хүрээнд 6 аймагт /Дорнод, Дархан, Архангай, Хөвсгөл, Ховд, Дундговь/ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийг байгуулна. Тус төвүүдээр 4 жилийн хугацаанд 90,000 хүүхэд оношлогдож, 5535 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрт хөгжүүлэх үйлчилгээнд хамрагдана.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт, үйлчилгээ, бизнес инкубаторын төвийг байгуулна. Тус төвөөр үйлчлүүлснээр 5000 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажлын байртай болно.

Түүнчлэн тус төвүүдэд ажиллах гол 104 үндсэн мэргэжилтэнг бэлтгэх юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

Энэ бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг гаргах үндэслэл болох хууль эрх зүйн орчин, мэдээллийн эх үүсвэр, арга зүй, тооцож буй үндсэн үзүүлэлт, тулгарч буй хүндрэл бэрхшээл болон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар танилцуулж байна.

Ойлголт, тодорхойлолт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие мах бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулна.

Албан ёсны статистикийн мэдээлэл буюу Нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоос хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлийг төрөлхийн ба олдмол гэсэн ангиллаар тодорхойлсон. Тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн, амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулж байна.

Тус үзүүлэлтийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг бие мах бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотойгоор бөгөөд харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, хавсарсан, бусад гэсэн ангиллаар авч үзэж байна.

Холбогдох хууль тогтоомж

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулах, шинжлэн судалж, тооцон гаргахад дараах хууль эрх зүйн баримт бичиг, хөтөлбөр, дэлхийн болон үндэсний хэмжээний хөгжлийн стратегийг үндэслэл болгож байна. Үүнд:

1. Хууль:

- Монгол Улсын Статистикийн тухай хууль (2016)
- Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)

2. Хөтөлбөр:

- Албан ёсны статистикийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2017-2020)

3. Конвенц:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (Монгол Улс 2009 онд соёрхон баталсан)
- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (Монгол Улс 1990 онд соёрхон баталсан)

4. Хөгжлийн стратеги:

- Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт - 2030
- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030
- Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан
“Эрхийг бодитой болгоё” Инчеоны стратеги

Монгол Улсын Засгийн газар нь дээр дурдсан конвенц, хууль, урт болон богино хугацааны хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэх, бодлогыг төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтийг

үнэлж, дүгнэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг ашиглаж байна.

Үйл ажиллагаа ба арга зүй

Мэдээллийн эх үүсвэр

Дэлхийн улс орнууд 1800 оноос хойш хөгжлийн бэрхшээлийн талаарх тоо мэдээллийг цуглуулж эхэлсэн бөгөөд сүүлийн 60 жилд энэ төрлийн мэдээллийг цуглуулах улс орны тоо нэмэгдэж байна. АНУ, Энэтхэг болон Португал зэрэг улсууд 19 дүгээр зууны туршид хүн амын тооллогын асуулгандаа хөгжлийн бэрхшээлийн асуултыг оруулж судалсан түүхтэй байдаг. Өнөөгийн байдлаар дэлхийн 198 улс орнууд 700 гаруй тооллого, өрхөд суурилсан түүвэр судалгаагаар хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг гаргаж байна¹.

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг албан ёсны статистик болон захиргааны бүртгэл мэдээллийг авч ашиглаж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлийн асуудал нь олон салбарт хамаарагдах асуудал учраас салбар бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тоо мэдээллийг гаргахад чиглэгдэж байна.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу Үндэсний статистикийн хорооноос баталсан аргачлал, үзүүлэлтээр гаргаж байгаа, мөн статистикийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мэдээллийг албан ёсны статистикийн мэдээлэл гэж ойлгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх албан ёсны статистик мэдээллийг дараах үндсэн 3 эх үүсвэрээс (Хүснэгт1) гаргаж байна. Үүнд:

- Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗҮ-1)-гээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг харуулсан мэдээллийг жил бүр гаргаж байна. Энэ мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй гэж

тодорхойлсон хүнийг хамруулж байна.

- Хүн ам, орон сууцны тооллого: Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүн ам зүй, нийгэм эдийн засгийн болон ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг цогцоор судлан тодорхойлох зорилгоор Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулж нийтэд тархаасан юм.
- Өрхөд суурилсан түүвэр судалгаа: Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөөлж болохуйц тодорхой хэсгийг сонгон авч дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх замаар бодлого хөтөлбөрийн үр дүнг дүгнэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь мэдээллийг гаргаж байна. Үндэсний статистикийн хороо нь тогтмол хугацааны давтамжтайгаар өрхөд суурилсан түүвэр судалгаануудыг зохион байгуулдаг бөгөөд эдгээр судалгаа нь өөр өөрийн гэсэн тодорхой зорилго, агуулгын хүрээнд боловсруулсан арга зүйг ашигладаг. Тухайлбал, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь дэлгэрэнгүй асуулгаар тэгш тоотой жилүүдэд явагдаж байгаа бөгөөд хүн амын эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл гаргуулж байгаа бөгөөд 2018 оноос Вашингтон бүлгийн богино багц асуултын дагуу хөгжлийн бэрхшээлийг судалж байна.

Түүнчлэн “Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлага” судалгааг 2017 онд анх удаа хийж, Вашингтон бүлгийн хөгжлийн бэрхшээлийн богино багц асуултын хүрээнд 15-64 насны эмэгтэйчүүдийн хөгжлийн бэрхшээлийн байдлыг судалсан юм.

Мөн Ажиллах хүчний судалгаа нь олон улсад мөрдөж буй нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн, тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачлалаар тооцох замаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодорхойлон, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар болон хөгжлийн бэрхшээлийг судалж, улирлын нөлөөллийг тусган тооцож байна.

Хүснэгт 1. Мэдээллийн эх үүсвэр, төрлөөр

Үндэсний статистикийн хороо		Засгийн газар	
Албан ёсны статистикийн статистик	Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (жил бүр) • Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нас, хүйс, төрөл, хэлбэр	Захиргааны бүртгэл, тайлан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам • Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо
	Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого Хүн ам, өрхийн мэдээллийн сан • Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нас, хүйс, төрөл, хэлбэр		Эрүүл мэндийн яам • Бүх шатлалын эмнэлгээр үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо • Эрүүл мэндийн даатгалаас үйлчилгээ авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо
	Өрхөд суурилсан судалгаа: • Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа • Ажиллах хүчний судалгаа • Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа • Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлагын судалгаа • Хүүхэд хөгжил судалгаа (Хөвсгөл аймаг, Улаанбаатар-Налайх дүүрэг)-2016 • Вашингтон бүлгийн өргөтгөсөн багц асуултын ойлгомжтой байдлыг турших судалгаа		Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам • Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ авсан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, зарцуулсан хөрөнгө • Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ авсан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, зарцуулсан хөрөнгө • Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бодлого, хөтөлбөр боловсруулах, үнэлж дүгнэхэд албан ёсны статистикийн мэдээллийн буюу Үндэсний статистикийн хорооны Нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээг ашиглаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны бүртгэл мэдээллээр Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоос хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон хүмүүсийн талаарх мэдээлэл буюу сургуулийн өмнөх болон суурь боловсрол, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүх шатны эмнэлэгт хандсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх тоо мэдээлэл гарч байна.


Үндсэн үзүүлэлт

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр 2018 оны эцэст Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 105.7 мянган иргэн байгаагийн 59.7 мянга нь эрэгтэйчүүд, 46.0 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44.4 хувь нь төрөлхийн, 55.6 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Энэ нь хүн амын дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өндөр байгааг харуулж байна.

Улаанбаатар хотын хувьд 2018 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 35.6 мянган иргэн байгаагийн 19.7 мянга нь эрэгтэйчүүд, 15.9 мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, төрлөөр, 2018

он



Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох шалтгааны нэг нь осол болж байгаатай холбоотой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг бэрхшээлийн төрөл, насаар авч үзэхэд бага, залуу насныхны дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол өндөр байснаа нас ахихын хэрээр олдмол бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэх хандлага байна. (Хүснэгт 2) Энэ хандлага Улаанбаатар хотын хувьд ч адил байна.

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, насны бүлэг, төрлөөр, 2018 он

Насны бүлэг	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр			
			Төрөлхийн		Олдмол	
	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь
Бүгд	105 691	100.0	46 958	44.4	58 733	55.6
0-4	2 026	1.9	1 700	3.6	326	0.5
5-9	3 551	3.3	2 831	6.0	720	1.2
10-14	3 431	3.2	2 581	5.5	850	1.4
15	755	0.7	573	1.2	182	0.3
16	749	0.7	520	1.1	229	0.4
17	825	0.78	548	1.7	277	0.5
18	889	0.8	559	1.2	330	0.6
19	1 188	1.2	723	1.5	465	0.8
20-34	21 918	20.7	11 681	24.8	10 237	17.4
35-64	64 335	60.8	23 293	49.6	41 042	69.8
65, түүнээс дээш	6 024	5.6	1 949	4.1	4 075	6.9
Улаанбаатар	35 589	100.0	15 956	34.0	19 633	33.4
0-4	877	2.4	754	4.7	123	0.6
5-9	1 498	4.2	1 223	7.6	275	1.4
10-14	1 278	3.6	982	6.1	296	1.5
15	255	0.7	204	1.2	51	0.2
16	210	0.6	145	0.9	65	0.3
17	254	0.7	173	1.0	81	0.4
18	280	0.8	190	1.2	90	0.4
19	361	1.0	220	1.4	141	0.7
20-34	7 399	20.7	3 668	23.0	3 731	19.0
35-64	21 414	60.0	7 930	50.0	13 484	68.6
65, түүнээс дээш	1 763	5.0	467	2.9	1 296	6.6

Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амыг бэрхшээлийн хэлбэрээр авч үзэхэд

хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 20.4 хувь (21.6 мянга), ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн бага буюу 4.1 хувь (4.3 мянга) байна. Харин Улаанбаатар хотод сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 18.8 хувь (6.7 мянга), ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн бага буюу 4.8 хувь (1.7 мянга) байна.

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хэлбэрээр, 2017-2018 он

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	2017 он				2018 он			
	Улсын хэмжээнд		Улаанбаатар хот		Улсын хэмжээнд		Улаанбаатар хот	
	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь
Бүгд	103 630	100.0	34 246	100.0	105 691	100.0	35 589	100.0
Хараа	11 071	10.6	3 068	8.9	11 519	10.9	3 336	9.4
Яриа	4 228	4.0	1588	4.6	4 312	4.1	1 698	4.8
Сонсгол	8 554	8.2	2 810	8.2	8 439	8.0	2 759	7.7
Хөдөлгөөн	20 688	19.9	5 638	16.4	21 598	20.4	6 207	17.4
Сэтгэц	19 733	19.0	6 093	17.7	20 364	19.3	6 679	18.8
Хавсарсан	7 842	7.5	3 502	10.2	7 278	6.9	3 244	9.1
Бусад	31 514	30.4	11 547	33.7	32 181	30.4	11 666	32.8

Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 35.6 мянган хүн амьдарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 33.7 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 70.1 мянга буюу 66.3 хувь нь аймаг, орон нутагт амьдарч байна.

Хүснэгт 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо (ҮСХ 2014-2018 он)

№	Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
1.	Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	99573	101730	100993	103630	105691
2.	- Төрөлхийн	35681	41550	43082	44384	46958
3.	- Олдмол	61379	57888	55809	57137	56136
4.	0-15 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	11365	7840	8151	8835	9008
5.	Хараа	9652	10925	11001	11071	11519
6.	Сонсгол	8304	8406	8560	8554	8439
7.	Хэл яриа	5294	4491	4367	4228	4312
8.	Хөдөлгөөн	18411	20110	20127	20688	21598

9.	Сэтгэц	16997	18433	18359	19733	20364
10.	Хавсарсан	10116	7912	8052	7842	7278
11.	Бусад	30799	31453	30527	31514	32181

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсын нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог 2014-2018 оны байдлаар харахад 6118 буюу 6.1 хувиар өссөн байна. Төрөлхийн бэрхшээлтэй хүний тоо 11277 буюу 31.6 хувиар нэмэгдсэн, олдмол бэрхшээлтэй хүний тоо 5243 буюу 8.5 хувиар буурсан байна.

Түүнчлэн 0-15 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2357 буюу 20.7 хувиар буурсан, харааны бэрхшээлтэй хүний тоо 1867 буюу 19.3 хувиар нэмэгдсэн, сонсголын бэрхшээлтэй хүний тоо 135 буюу 1.6 хувиар нэмэгдсэн, хэл ярианы бэрхшээлтэй хүний тоо 982 буюу 18.5 хувиар буурсан, хөдөлгөөний бэрхшээлтэй хүний тоо 3187 буюу 17.3 хувиар нэмэгдсэн, сэтгэцийн бэрхшээлтэй хүний тоо 3367 буюу 19.8 хувиар нэмэгдсэн, хавсарсан бэрхшээлтэй хүний тоо 2838 буюу 28 хувиар буурсан, бусад төрлийн бэрхшээлтэй хүний тоо 1382 буюу 4.4 хувиар нэмэгдсэн тус тус үзүүлэлттэй гарсан байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Дэлхийн ихэнх улс орнуудын хөгжлийн бэрхшээлийн статистикийн уламжлалт чиг хандлага зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол сүүлийн үед уг ойлголт нь өргөжин, тэдгээрийн нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй өдөр тутмын хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээг тодорхойлох зэрэг өргөн агуулгатай болж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь бусдын адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, сайн сайхан амьдрах ёстой гэсэн үзэл санаанд үндэслэн хөгжиж байна. Үүнтэй уялдаж хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг сайжруулах хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг сайжруулах ажлын хүрээнд:

- Тоо мэдээллийн нэгдмэл байдлыг хангаж албан ёсны болон захиргааны мэдээлэл, цахим мэдээллийн сангуудын уялдааг хангах, статистикийн зорилгоор ашиглах боломжийг нэмэгдүүлэх;
- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнд үндэслэн зорилтот түүвэр судалгаа зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй саад тотгор, бэрхшээл, түүний шалтгааныг тодруулан судлах чиглэлээр тоон болон чанарын судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх тоо мэдээллийг төрийн бодлого, хөтөлбөр, үйлчилгээг зөв оновчтой төлөвлөхөд ашиглах;
- Олон улсын ангиллыг үндэсний онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх, тоо

-
- мэдээллийн олон улсад харьцуулагдахуйц байдлыг нэмэгдүүлэх;
 - Инчеоны стратегийн хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтийг тооцох;
 - Тоо мэдээллийн хүртээмж, ашиглалтыг нэмэгдүүлэх ялангуяа, хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх;
 - Дэлхийн болон үндэсний тогтвортой хөгжлийн зорилтыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тооцох, тайлагнах зэрэг болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сан байгуулах үзлэг, тооллогын талаар:

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилт, Инчеоны стратеги, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээлэл, үзүүлэлтийн зөрүүтэй байдал арилгах, мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдагч мэдээллийн сан байгуулах үзлэг, тооллогын Үндэсний статистикийн хороотой хамтран зохион байгуулж байна.

Энэ хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдагч мэдээллийн сан байгуулах үзлэг, тооллого зохион байгуулах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/89, А/42 тоот хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Энэ хүрээнд үзлэг тооллогын бэлтгэлийг хангах, иргэдээс мэдээлэл цуглуулах асуулгыг эцэслэх зорилгоор туршилтын үзлэг, тооллогыг 2018 оны 05 дугаар сарын 06-12-ны хооронд Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант, Сэлэнгэ аймгийн Орхон сумдад зохион байгууллаа. Ингэхдээ баг, хороодын Засаг дарга нарын хөтөлдөг Хүн ам, өрхийн мэдээллийн сан дахь мэдээлэлд үндэслэн зорилтот бүлгийн өрхүүдийг сонгосон. Түүнчлэн энгийн санамсаргүй түүврийн аргыг ашиглан өрхүүдээр биечлэн орж асуулгаа туршсан юм.

Мөн Үндэсний статистикийн хорооны Хүн ам, өрхийн мэдээллийн сантай хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт ашиглагдаж байгаа Нийгмийн даатгалын мэдээллийн сан, Нийгмийн халамжийн удирдлагын мэдээллийн сан (WAIS) дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийг тулгаж, зөрөөг арилгах ажлыг зохион байгуулж байна.

Асуулгын хуудсыг өрхийн бүртгэл, байгууллагын асуулга, 5-аас дээш насны иргэдээс авах ганцаарчилсан ярилцлага, сургуулийн өмнөх боловсрол буюу 0-5 насны хүүхдээс авах ганцаарчилсан ярилцлагын хэлбэрээр тус тус боловсруулан туршив. Туршилтын үзлэгт 23 өрхийн 87 иргэн, зорилтот бүлэг буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй 19 өрхийн 49 иргэн, байгууллагын туршилтын асуулгад 38 байгууллага хамрагдсан. Асуулгад Вашингтон бүлгийн богино асуулгыг ашигласнаараа онцлог

болсон юм.

Үзлэг тооллогын ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэл, мэдээллийн чанарыг судлах, цахим мэдээллийн дэд сан байгуулах ажлыг эхлүүлэн Норвегийн тусламжийн байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих бэлтгэл төсөл”-ийн дэмжлэгтэйгээр Баян-Өлгий аймагт туршилтын тооллогын ажлыг зохион байгууллаа.

Туршилтын тооллогод бэлтгэл ажлаас дурдвал : Хүн ам, өрхийн мэдээлийн сан болон Нийгмийн халамжийн удирдлагын мэдээллийн сан (WAIS) дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийг хүн нэг бүрээр тулгаж мэдээллийн давхардал, зөрүүтэй байдлыг шалгасан. Үүний дараагаар тухайн аймгийн Засаг даргын Тамгын газарт хүмүүсийн зөрсөн мэдээллийг сайжруулахаар тодруулга авч улмаар тоологч тус бүрт ногдох өрхийн жагсаалтыг гаргаж, мэдээлэл цуглуулах таблет төхөөрөмж тус бүрт оролтын программын хамт суулгасан. Тоологч нарыг бэлтгэх сургалтыг 2 өдөр, мэдээлэл цуглуулах ажлыг 14 хоногийн хугацаатай зохион байгууллаа.

Уг тооллогыг Ховд аймагт 2019 оны 02 дугаар сарын сүүлээр эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны талаар:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дугаар зүйл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан тогтоол, тушаал, журмын хэрэгжилтэд шинжилгээ хийх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-г хийлээ.

Тус судалгаагаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн сангаас Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дугаар заалтыг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны тоон мэдээнд шинжилгээ хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах өнөөгийн боломж, бололцоог тооцоолсон. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллуулж байгаа, төлбөр төлж байгаа, хуулийг хэрэгжүүлдэггүй байгууллагуудын төлөөлөл болгон 117 аж ахуйн нэгж байгууллага, түүнчлэн хөдөлмөр эрхэлж байгаа болон ажил хайж буй 142 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан тоон судалгааг бүсийн төлөөлөл 4 аймаг, Улаанбаатар хотод хийж гүйцэтгэсэн.

Энэхүү судалгаа нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дугаар заалтуудыг хэрэгжүүлж буй болон хууль хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагууд, нөгөө талаас хөдөлмөр эрхэлж байгаа болон ажилгүй байгаа хөгжлийн

бэрхшээлтэй иргэд зэрэг бүх оролцогч талыг хамруулан, судалснаар онцлог юм.

Тухайлбал: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.2-д /төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, стратеги, хөтөлбөрийн талаар санал боловсруулах, хэлэлцэх, энэ хуулийн 6.3.1-6.3.4, 6.3.6-д заасан төсөл, хөтөлбөрийг хэлэлцэн батлах/ заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг баталж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, хэлтсүүд зохион байгуулж, хариуцан хэрэгжүүлж ирсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулдаг байна.

Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг арга хэмжээ, төсөвт өртөг.

№	Үйлчилгээ	Төсөвт өртгийн дээд хязгаар /₮/	Хариуцан хэрэгжүүлэгч	Холбогдох эрх зүйн заалт
1	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	70.000 /ХБИ1 хүнд/	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 3.2.7 дахь заалт,
2	Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	3.500 /1 цагийн/	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны А/18 тоот тушаал
3	Санхүүгийн дэмжлэг	5.000.000 /1 удаад/	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 3.4.1 дэх заалт,
4	Аж ахуй эрхлэлтийн сургалт	15.000 /3 хоног/	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 3.6.2 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр

				сарын 27-ны А/18 тоот тушаал
5	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	16.000-40.000 /1 өдрийн ХБИ 30% нэмэгдэл/	Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 3.7.3 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны А/18 тоот тушаал
6	Борлуулалтын дэмжлэг	700.000 /1 удаад/	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 3.6.2 дахь заалт,
7	Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг	250.000 /1 сард/	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны А/18 тоот тушаал
8	Ажил олгогчийн урамшуулал	500.000 /Цалингийн дээд хэмжээ/	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны А/18 тоот тушаал
9	ТББ, ААНБ-аар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	30.000.000-50.000.000	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухайхуулийн 2 дугаар бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 4.2.2 дахь заалт,

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 5.0 сая хүртэл төгрөгийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг /2016 оных эргэн төлөлтгүй/, борлуулалтын болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, ажил олгогчийн урамшуулал, аж ахуй эрхлэлтийн сургалтыг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөр эрхлэлтийн буюу мэргэжил олгох сургалтыг Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар зохион байгуулж байгаа бол төрийн бус байгууллагад эргэн төлөлтгүй, компани эргэн төлөх нөхцөлтэй тохируулгатай ажлын байр бий болгох үйл ажиллагааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Судалгааны үр дүнд дараах зөвлөмжийг гаргажээ.

- Хуулийн хэрэгжилт эдийн засгийн үйл ажиллагааны бүхий л салбарт хангалтгүй байгаа бөгөөд тээвэр, барилгын салбарт бусад салбаруудаас харьцангуй доогуур байгааг анхаарах;
- Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл заалтын хууль санаачлагчийн хүсэл зоригийг аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч болон төрийн байгууллагын шийдвэр гаргагчдад ойлгуулах, сурталчлах;
- Хуулийн хэрэгжилтийг төлбөр төлснөөр хязгаарлах биш, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллуулах нь давуу тал болохыг таниулах ажлыг зохион байгуулах;
- Ажил олгогчдод эерэг хандлагыг төлөвшүүлэх, татварын болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн урамшууллыг сурталчлах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх. Мөн тохируулгатай ажлын байр бүрдүүлсэн тохиолдолд гаргасан зардалд татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлах;
- Хуулийн тус заалтын хэрэгжилттэй холбоотой захиргааны тоон мэдээллийн загвараар хандлагыг улирал бүр гаргаж, хуулийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллуулах квотыг ажлын байрны нөхцөл, боломжийг харгалзан эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ялгаатай тогтоох боломжийг нарийвчлан судлах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэх чадавхийг зөв тодорхойлсон мэдээллийн санг хөгжүүлэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт зуучлах ажлыг эрчимжүүлэх, энэхүү ажилд мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг уялдуулах гэх мэт.

Түүнчлэн тус судалгааны тайлангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх өнөөгийн байдал, хуулийн хэрэгжилтийг хангах боломж, бололцооны талаар захиргааны тоон мэдээллийг авах боломжтой.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Холбогдох хууль тогтоомж

1. **Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030**
(Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан).

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ

Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчмын хүрээнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ гэж заасан.

2. **Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого**
(Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор батлагдсан).

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчин бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

Бодлогын зорилт:

- 4.1. “Хүн амын тогтвортой өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх” чиглэлээр:

4.1.14. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулж, осол, гэмтлийн улмаас нас барах явдлыг тогтвортой бууруулах, хүн амыг олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх;

4.1.15. хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх;

- 4.3. “Гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах”
чиглэлээр:

4.3.8. олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй болон өрх толгойлсон эцэг, эх бүхий гэр бүл, ганц бие ахмад настанд дэмжлэг үзүүлж амьдралын түвшинг дээшлүүлэх;

4.3.9. хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн үйлчилгээг хүртэх, гэр бүл, нийгмийн амьдралд идэвхтэй, тэгш оролцоход ээлтэй, хүртээмжтэй орчныг бий болгох;

4.4. “Хүн бүр боловсрол эзэмших, хөгжих боломжийг бүрдүүлэх” чиглэлээр:

4.4.5. хөгжлийн бэрхшээлтэй зэрэг тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай иргэдийн боловсролын хэрэгцээг хангах, боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах орчныг бүрдүүлэх;

4.5. “Хүн амыг ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх” чиглэлээр:

4.5.1. байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадамжид тохирсон ажлын байрыг бий болгохыг урамшуулах;

4.5.5. эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх талаар тусгасан байна.

3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Энэхүү хөтөлбөрийн “Нийгмийн бодлого” буюу гуравдугаар бүлгийн 3.3-т Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан. Үүнд:

3.3.28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална;

3.3.29. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна;

3.3.30. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ гэж заасан.

4. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” 2018~2022 он

Тус үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/116, А/304, А/197 тоот хамтарсан тушаалаар батлууллаа.

/Хөтөлбөрийн төлөвлөгөөг хавсралт хэсгээс үзнэ үү./

5. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтанд хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд оршино.

6. Олон улсын баримт бичиг:

- Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ 1989 он
- Саламанкагийн тунхаглал “Тусгай хэрэгцээт боловсролын талаар гаргасан баримт бичиг” 1994 он
- Дакарын үйл ажиллагааны хүрээ “Бүх нийтийн боловсролын талаар гаргасан баримт бичиг” 2000 он
- “Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF ангилал)” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2001 он
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх хамтарсан бичиг баримт” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага 2004 он
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, НҮБ 2006 он
- “Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын Удирдамж” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хөгжил, хөгжлийн бэрхшээлийн олон улсын консорциум 2010 он
- “Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк 2011 он
- Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын дэлхийн анхдугаар чуулганаас гаргасан “АГРА Тунхаглал” 2012 он
- Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги 2012 он

7. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой Монгол Улсын хууль:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он
- Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 он
- Нийгмийн даатгалын тухай хууль 1994 он
- Нийгмийн халамжийн тухай хууль 2012 он
- Боловсролын багц хууль 2002 он
- Барилгын тухай хууль 2016 он

- Эрүүл мэндийн тухай хууль 2011 он
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль 2006 он
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 2015 он
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 2008 он
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2006 он
- Бусад холбогдох хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын холбогдох тогтоол, журам

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг хариуцсан байгууллагын чиг үүргийг тодорхой болгох, хуулийн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, хууль хоорондын нийцлийг хангах, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу батлан мөрдүүлэх боловч батлагдаагүй 15 журмаар зохицуулах шаардлагатай зарим харилцааг салбар хуулиар зохицуулахаар тусгах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сайжруулах, зарим нэр томъёог олон улсын гэрээнд нийцүүлэн өөрчлөх зэрэг асуудлыг шийдвэрлэх юм.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлигаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, зарим дүрэм, журмыг баталж мөрдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн. Энэ ажлын хүрээнд бүх яам, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо зэрэг байгууллагад тус зарлигийн хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллах санал хүргүүлсэн. Мөн хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт тус зарлигийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2018 оны А/305 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хороотой хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2017 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үеэр бүх яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн авч хэрэгжүүлсэн ажил, тулгамдаж байгаа асуудлын талаар ярилцаж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар чиглэл өгсөн. Түүнчлэн дээрх асуудлыг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх

ухааны байнгын хорооны хурлаар хэлэлцэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, цаашид авах арга хэмжээний талаар УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсгийг УИХ-ын Байнгын хорооны 2018 оны 23 дугаар тогтоолоор байгуулсан болно.

- Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний стандартын төслийг Нийгмийн хамгаалал, халамжийн стандартчилалын техникийн хороогоор хэлэлцүүлж, батлууллаа. Тус стандартыг хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүртээмж зэрэг нийгмийн бүхий л хүрээнд тэгш оролцох боломж, нөхцөл бүрдэх юм.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1. Нийгмийн даатгал

1. Хууль тогтоомж:

Нийгмийн даатгалын дараах хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

2. Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох нь:

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс даатгуулагч /иргэн/-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоодог байгууллага юм.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комисс, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг мэргэжлийн түвшинд тогтоох үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын зорилго нь ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас иргэн хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас /хэсэгчлэн/ алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг магадлан шийдвэрлэх зорилготой юм.

Комиссын бүрэлдэхүүнд аймаг, дүүргийн (2 дахь шатлал) эмнэлгийн эмч мэргэжилтэн оролцуулсан 7-9 хүнээс бүрдэх ба дотор, мэдрэл, мэс заслын эмч, нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч, нийгмийн даатгалын хэлтсийн ажилтан, нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, ажил олгогчийн төлөөлөл, даатгуулагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

Харин Төв комиссын бүрэлдэхүүнд нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн шинжээч эмч нар, ажил олгогчийн төлөөлөл

15 хүнтэй байна.

Иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг бүрэн алдсан буюу 70- аас дээш хувь, хагас алдсан буюу 50-69 хувиар алдсан гэж 2 ангилдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар “0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тодорхойлно” гэж заасны дагуу аймаг, дүүрэг бүрт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү комисс нь 0-16 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлон, байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тогтоон эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц хөтөлбөрт хамруулах ажлын зохион байгуулж байна.

2018 онд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч иргэн 111203 байгаа нь нийт хүн амын 3,7 хувийг эзэлж байна. Үүнээс дотор, сэтгэцийн эмгэг, мэдрэлийн өвчин, ахуйн осол, нүдний өвчин нь хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болж байгаа ба нийт хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн 75.9 хувийг эзэлж байна.

3. Нийгмийн даатгалын үйлчилгээний төрөл:

Даатгуулагчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг дараах даатгалын төрлөөс олгож байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгал
- Тэтгэмжийн даатгал
- Ажилгүйдлийн даатгал
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал
- Эрүүл мэндийн даатгал

3.1.Өндөр насны тэтгэвэр:

Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно. Цаашдаа 3 насаар нэмэгдүүлэх замаар тэтгэвэр тогтоолгох насыг эрэгтэй, эмэгтэй хүний хувьд адилхан 65 болгох юм... 2018 оноос өндөр насны тэтгэврийн насыг тухайн даатгуулагчийн төрсөн оноос хамаарч жил бүр 3 сараар нэмэгдүүлэхээр болсон.

Тухайлбал, эрэгтэй даатгуулагч 1958 онд төрсөн бол 60 нас 3 сартайдаа, 1959 онд төрсөн бол 60 нас 6 сартайдаа, 1960 онд төрсөн бол 60 нас 9 сартайдаа, эмэгтэй даатгуулагчийн хувьд 1963 онд төрсөн бол 55 нас 3 сартайдаа, 1964 онд төрсөн бол 55 нас 6 сартайдаа, 1965 онд төрсөн бол 55 нас 9 сартайдаа тус тус өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Хүснэгт 6. Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх нас

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас	Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас
1957 ба түүнээс өмнө	60 нас	1962 ба түүнээс өмнө	55 нас
1958	60 нас 3 сар	1963	55 нас 3 сар
1959	60 нас 6 сар	1964	55 нас 6 сар
1960	60 нас 9 сар	1965	55 нас 9 сар
1961	61 нас	1966	56 нас
1962	61 нас 3 сар	1967	56 нас 3 сар
1963	61 нас 6 сар	1968	56 нас 6 сар
1964	61 нас 9 сар	1969	56 нас 9 сар
1965	62 нас	1970	57 нас
1966	62 нас 3 сар	1971	57 нас 3 сар
1967	62 нас 6 сар	1972	57 нас 6 сар
1968	62 нас 9 сар	1973	57 нас 9 сар
1969	63 нас	1974	58 нас
1970	63 нас 3 сар	1975	58 нас 3 сар
1971	63 нас 6 сар	1976	58 нас 6 сар
1972	63 нас 9 сар	1977	58 нас 9 сар
1973	64 нас	1978	59 нас
1974	64 нас 3 сар	1979	59 нас 3 сар
1975	64 нас 6 сар	1980	59 нас 6 сар
1976	64 нас 9 сар	1981	59 нас 9 сар
1977 ба түүнээс хойш	65 нас	1982	60 нас
		1983	60 нас 3 сар
		1984	60 нас 6 сар
		1985	60 нас 9 сар
		1986	61 нас
		1987	61 нас 3 сар
		1988	61 нас 6 сар
		1989	61 нас 9 сар
		1990	62 нас
		1991	62 нас 3 сар
		1992	62 нас 6 сар
		1993	62 нас 9 сар
		1994	63 нас
		1995	63 нас 3 сар

		1996	63 нас 6 сар
		1997	63 нас 9 сар
		1998	64 нас
		1999	64 нас 3 сар
		2000	64 нас 6 сар
		2001	64 нас 9 сар
		2002 ба түүнээс хойш	65 нас

Даатгуулагч өөрөө хүсвэл доор дурдсан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан бол эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насанд хүрээд өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа (20 жил)-г 2018 оноос жил бүр 3 сараар нэмэгдүүлсэн. Тухайлбал, даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 2018 онд 20 жил 3 сар, 2019 онд 20 жил 6 сар, 2020 онд 20 жил 9 сар, 2021 онд 21 жил байна.

Хүснэгт 7. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа

Он	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацаа
2017	20 жил
2018	"20 жил 3 сар"
2019	"20 жил 6 сар"
2020	"20 жил 9 сар"
2021	21 жил
2022	"21 жил 3 сар"
2023	"21 жил 6 сар"
2024	"21 жил 9 сар"
2025	22 жил
2026	"22 жил 3 сар"
2027	"22 жил 6 сар"
2028	"22 жил 9 сар"
2029	23 жил
2030	"23 жил 3 сар"
2031	"23 жил 6 сар"
2032	"23 жил 9 сар"
2033	24 жил
2034	"24 жил 3 сар"
2035	"24 жил 6 сар"
2036	"24 жил 9 сар"
2037	"25 жил"

Өндөр насны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл (тооцох аргачлал)

Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сарын дундаж цалингийн

45 хувиар өндөр насны тэтгэврийг тогтооно. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар бодож нэмэгдэл олгоно.

Хувь тэнцүүлсэн тэтгэвэр

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны болзол хангасан даатгуулагч шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгоно.

Хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тогтоолгох тэтгэвэр

- Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан, дөрөв түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр тэтгэвэр тогтоолгон авна.
- Газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагч хуульд заасан шимтгэл төлөх хугацааны болзол хангасан тохиолдолд эрэгтэй 50, 55, эмэгтэй 45 нас хүрээд тэтгэвэр тогтоолгон авна.

Тэтгэврийн нэмэгдэл

Монгол Улсын Засгийн газраас тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 2014 онд 207300 төгрөг, 2015 онд 230000 төгрөг, 2016 онд 251000 төгрөг, 2018 онд 280000 төгрөг, 2019 онд 310000 төгрөгөөр, харин хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 2014 онд 172200 төгрөг, 2015 онд 195000 төгрөг, 2016 онд 216000 төгрөг, 2018 онд 243000 төгрөг, 2019 онд 270000 төгрөгт хүргэж тус тус нэмэгдүүлсэн.

3.2. Тахир дутуугийн тэтгэвэр

“Тахир дутуугийн тэтгэвэр” гэдэг нь ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа байнга, эсхүл удаан хугацаанд алдсан даатгуулагч иргэнд хуульд заасан шимтгэл төлөх болзлыг хангасан тохиолдолд түүний хөдөлмөрийн чадвар алдсан хугацаанаас эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл амьжиргааны эх үүсвэр болгон сар бүр олгож байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тахир дутуугийн бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх

- Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга, эсхүл удаан хугацаагаар алдсан;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн, эсхүл хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх 5 жилийн дотор нийтдээ 36 сар буюу 3 жилд шимтгэл төлсөн байна.

Тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох эрх

- Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар тогтоолгосон байх;
- Нийтдээ 3-аас 20 хүртэл жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байх.

Тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт материал

Бүрдүүлэх материал:

- Нийгмийн даатгалын дэвтэр
- 1995 оноос өмнөх хугацаанд ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр
- Хугацаат цэргийн алба хаасан бол цэргийн батлах, эсхүл архивын лавлагаа
- 1995 оноос өмнөх 5 жилийн цалин хөлсийг сонгосон тохиолдолд батлагдсан маягтын дагуу тухайн ажиллаж байсан аж ахуйн нэгж байгууллагаар, эсхүл архивын сан хөмрөгөөс гаргуулсан лавлагаа
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр
- Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл
- Иргэний үнэмлэх
- 2 хувь цээж зураг /3*4 хэмжээтэй/

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон тахир дутуугийн тэтгэвэр авч буй иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байгаа бол авч буй сарын цалин, хөлснөөсөө тооцуулж нийгмийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлдөг бол тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн хувьд сайн дураараа нийгмийн даатгалын шимтгэл төлөх эрх нь нээлттэй юм.

Сайн дураараа тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхдөө сарын орлогоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, шимтгэл төлөх орлогын сарын дээд хэмжээнээс ихгүй байхаар өөрөө тодорхойлно. Ийнхүү хуульд заагдсан өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас болон шимтгэл төлсөн байвал зохих хугацааны болзлыг хангасан тохиолдолд нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ. Тахир дутуугийн бүрэн тэтгэврийн доод хэмжээг

Монгол Улсын Засгийн газрын 26 дугаар тогтоолоор 2019 оны 02 дугаар сараас эхлэн 310000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 270000 төгрөгөөр тогтоосон.

3.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйлчилгээ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзахгүйгээр тахир дутуугийн тэтгэврийг сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогоос даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтоож олгоно.

“Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу даатгуулагчид дараах тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардлыг олгоно.

- Үүнд: 1/ тахир дутуугийн тэтгэвэр;
- 2/ тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- 3/ хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- 4/ хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр.
- 5/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл;
- 6/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын даатгуулагчийг сувилахад ногдох тусламж үйлчилгээний хувьсах зардал;
- 7/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагч нь рашаан сувилалд сувилуулсан тохиолдолд сувиллын зардал, ирж очих унааны зардлыг нийгмийн даатгалын байгууллагаас жилд нэг удаа хариуцан төлнө.

3.4. Ажилгүйдлийн тэтгэмж:

Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажлаас чөлөөлсөн тухай тушаал шийдвэр гарснаас өмнө нийтдээ 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн бол ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүснэ. Ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.

Уг тэтгэмжийг даатгуулагч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын хэлтэст бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр тооцож олгоно.

3.5. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж:

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнөх 3 ба түүнээс дээш сарын хугацаанд төлсөн даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авах эрхтэй. Даатгуулагчийн шимтгэл төлсөн сарын дундаж орлогын хэмжээнээс шимтгэл төлсөн хугацаанд хамаарах /50, 55, 75/ хувиар тооцож хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр бодож олгоно. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан ажлын эхний 5 өдрийн тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсвэл тахир дутуугийн тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацаанд ажлын 66 өдрийн, хуанлийн жилд удаа дараа өвдвөл ажлын 132 өдрийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллага олгоно.

Тулгамдаж буй асуудлууд

Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлж халдварт бус өвчнүүд, ахуйн ослоос шалтгаалсан хүн амын дундах өвчлөлийн түвшинг бууруулах хөдөлмөрийн чадвар алдахаас сэргийлэх, эрт илрүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч /иргэн/-ий эрүүл мэндийн байдлыг тогтмол хянах, эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах тусламж, үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар нийгмийн бүхий л түвшинд тэдний оролцоог нэмэгдүүлж, боловсрол эзэмшүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

2. Нийгмийн халамж

1. Холбогдох хууль тогтоомж

1. Нийгмийн халамжийн тухай хууль
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
3. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль
4. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүллээ.

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 27 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэмжийн хэмжээг сард 174,000 төгрөгөөр, асаргааны тэтгэмжийн хэмжээг 76,000 төгрөгөөр тогтоон 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхлээд байна.

Байнгын асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар баталлаа.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.4-т заасан “эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэн”-д сар бүр асаргааны тэтгэмж олгодог.

Мөн хуулийн 13.11-д “Энэ хуулийн 13.2.4-т заасан ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин, гэмтлийн жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/69/48 дугаар хамтарсан тушаалаар “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалт шалгуур, үзүүлэлт”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийн дагуу ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний байнгын асаргаа шаардлагатай эсэхийг сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч, аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Эмнэлэг хяналтын комисс, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байнгын асаргаа шаардлагатай эсэхийг аймаг, дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс тодорхойлж байна.

Жагсаалт, шалгуур үзүүлэлт батлагдсанаар асаргаа шаардлагатай иргэнийг шинээр тодорхойлох, хугацааг сунгах, цуцлахад эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнүүд нэгдсэн ойлголт, нэг мөр мөрдөх баримт бичигтэй болж, асаргаа шаардлагатай иргэнийг үнэн зөв, оновчтой тогтоох боломжтой болсон.

Өвчин, гэмтлийн жагсаалт:

-Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох- 9 бүлэг, 82 онош

- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох -12 бүлэг, 54 онош

Шалгуур үзүүлэлт /үнэлгээний хуудас/:

- Байнгын асаргаа шаардлагатай иргэн – 12 үзүүлэлт
- Оюуны хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн- 14 үзүүлэлтээс тус тус бүрдэж байна.

2) Нийгмийн халамжийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

А. Тэтгэвэр, тэтгэмж

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу дараах тэтгэвэр, тэтгэмжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн авах эрхтэй.

Нийгмийн халамжийн тэтгэвэр

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1-д “Нийгмийн халамжийн тэтгэвэр /цаашид “тэтгэвэр” гэх/-ийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд сар бүр олгоно” гэж заасны дагуу

- Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- 16 насанд хүрсэн одой иргэд үүнд хамрагдаж байна.

Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 2013 онд 103,600 төгрөг байсан бол 2014 онд 115,000 төгрөг, 2015 онд 126.500 төгрөг, 2016 онд 140,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмж

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1-д заасан Нийгмийн халамжийн тэтгэмж /цаашид “тэтгэмж” гэх/ -ийг дараах төрөлд хөгжлийн бэрхшээлтэй хүн авах боломжтой.

- Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;
- Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа;
- Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухайн үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламжийг /сар бүр 140,00 төгрөг/
- Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн /улирал бүр 60,000 төгрөг.

Б. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн халамжийн үйлчилгээ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу үйлчилгээ авч, тусламж, хөнгөлөлтийг эдлэх эрхтэй.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан дараах 9 төрлийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж байна.

18.1.1. амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;

18.1.2. зөвлөгөө өгөх;

18.1.3. сэргээн засах үйлчилгээнд хамруулах;

18.1.4. түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;

/Энэ заалтад 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

18.1.5. өдрийн үйлчилгээнд хамруулах;

18.1.6. гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;

18.1.7. иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;

18.1.8. гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;

18.1.9. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд харж хандах хүнгүй, бие даан амьдрах чадваргүй, асаргаа сувилгаа зайлшгүй шаардлагатай ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөлжсөн

асрамжийн үйлчилгээнд хамруулан байршуулж, хооллон, асаргаа сувилгаа, нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлж байна.

Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

1. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ /нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэн/

22.1.1.энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэдийн дотроос нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлсон хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

22.1.2.гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн.

22.2.Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь дараах хэлбэртэй байна:

22.2.1.хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгох;

22.2.2.халуун хоол, цайгаар үйлчлэх.

2. Боловсролыг дэмжих үйлчилгээ /сурах бичгийг үнэ төлбөргүй олгох/

20.2.Боловсролыг дэмжих үйлчилгээнд дараах иргэнийг хамруулна:

20.2.1.энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүүхэд;

20.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд;

20.2.3.бүтэн ба хагас өнчин хүүхэд;

20.2.4.гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэний хүүхэд;

20.2.5.төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд;

20.2.6.хорих ангиас суллагдсан хүүхэд.

20.2.7.энэ хуулийн 3.1.11-д заасан босго шугамаас доогуур амьжиргаатай өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд.

3. Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ /Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах/

21.1.Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээний хүрээнд дараах тусламж, дэмжлэг үзүүлнэ:

21.1.1.энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн-гишүүн иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлөх;

21.1.2.нийгмийн халамжид хамрагдагсдад үзүүлэх эрүүл мэндийн бусад үйлчилгээ

Хөнгөлөлт, тусламж

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан 17 төрлийн хөнгөлөлт, тусламжинд хамрагдаж байна.

/хавсралт 1-д Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиас дэлгэрэнгүй харна уу/

1/ байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай

хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

2/ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын

үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох;

3/ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг гурван жил тутам нэг удаа нөхөн олгох;

4/ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;

5/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх;

6/ насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;

7/ дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд ирж, очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон доор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгох:

- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь;

- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа нэг иргэнд 50 хувь;
- үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувь.

8/ бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

9/ нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

10/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;

11/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа олгох;

12/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох;

13/ хараагүй хүний брайлийн үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;

14/ нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгох;

15/ аарцаг эрхтэний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх.

16/ хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулах;

17/ Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн болон тэдгээрийг асран хамгаалагчийг нийгмийн халамжийн үйлчилгээ, тусламжид

хамруулах;

18/ хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих хөнгөлөлт эдлэх.

ТАВДУГААР БҮЛЭГ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Холбогдох хууль тогтоомж

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг.

Түүнчлэн тус конвенцид мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагийг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөсөн.

Конвенцийн дагуу Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг эдлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар дараах хууль тогтоомжид тусгасан. Тухайлбал:

- Хөдөлмөрийн тухай хуульд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль төлбөр ногдуулах;
- Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулинд монгол иргэдийг авч ажиллуулж буй гадаад орны аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээний үндсэн нөхцөлд Монгол Улсын иргэн гадаад улсад хөдөлмөр эрхэлж байхдаа хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн буюу бүрэн алдсан тохиолдолд ажил олгогчоос ажилтанд олгох төлбөр, тэтгэмж, нөхөн төлбөрийн хэмжээг тусгах заалтыг шинээр нэмж оруулсан нь гадаадад ажиллаж буй монгол иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах боломжийг дээшлүүлэх;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулинд 25-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн нийт ажиллагсдын 2/3 ба түүнээс дээш хувийг хараагүй ажилтан эзэлдэг бол уг аж ахуйн нэгжийг орлогыг албан татвараас чөлөөлөх, 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн

бэрхшээлтэй иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийн хандивыг тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцож байх;

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд өөрт нь болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн тусламж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулахаар тус тус тусгасан байдаг.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтын дагуу төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолоор баталсан.

Хүснэгт 8. Аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ

№	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын	50 хүртэлх ажиллагчтай	51-ээс дээш ажиллагчтай
1	Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймаг	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 40 хувиар	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиар
2	Бусад аймаг		Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111.6-д “Аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө” /Энэ хэсгийг 2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/ гэж зохицуулсан. Энэхүү төлбөр нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрдөг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулсан төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулагдаж байгаа нийт хөрөнгийн 20 орчим хувийг бүрдүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтлах зорилтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг 2018 онд хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд 711 иргэнийг хамруулж 49.9 сая төгрөг;
- Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах арга хэмжээнд 137 иргэнийг хамруулж 13.1 сая төгрөг;
- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 688 иргэнийг хамруулж 2,021.6 сая төгрөг;
- Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 656 иргэнийг хамруулж 185.7 сая төгрөг;
- Аж ахуйн эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад 2279 иргэнийг хамруулж 68.3 сая төгрөг;
- Хөдөлмөр эхлэлтийн сургалтад 912 иргэнийг хамруулж 152.8 сая төгрөг;
- Ажил олгогчийн дэмжлэгт 312 иргэнийг тогтвортой ажлын байраар хангасан 312 ажил олгогчид 1,155.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг 2018 онд хэрэгжүүлэхэд 3,647.1 сая төгрөг зарцуулж, 5692 иргэн хамрагдаж, 1209 байнгын ажлын байр, 134 түр ажлын байр бий болсон байна.

Хүснэгт 9. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хамрагдалт, аймаг, нийслэл, дүүргээр, зарцуулсан хөрөнгө

Д/Д	Аймаг, дүүргүүд	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо	Аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдсан хүний тоо	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамрагдсан хүний тоо	Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	Нийт хамрагдсан хүний тоо	Нийт зарцуулсан хөрөнгө /мян.төг/
1.	Архангай	21		17	75	18	4	1	136	66,884
2.	Баян-Өлгий	23		21	64	21	11	2	142	80,605
3.	Баянхонгор	19		26	66	17	4	2	134	57,406
4.	Булган	16	2	24	54	14	38	2	150	52,312
5.	Говь- Алтай	15		24	54	15		1	109	48,670
6.	Дорноговь	16		11	56	11	5		99	47,490
7.	Дорнод	21	4	17	72	14	12	2	142	72,318
8.	Дундговь	15		7	51	5	2		80	44,525
9.	Завхан	23		10	79	16			128	59,076
10.	Өвөрхангай	26		25	94	19	6		170	75,304
11.	Өмнөговь	15		13	53				81	47,500
12.	Сүхбаатар	16		15	21	11	6		69	49,394
13.	Сэлэнгэ	26		10	89	18	2	3	148	44,619
14.	Төв	11		16	65	4	5		101	57,481
15.	Увс	21		24		21	250		316	62,989
16.	Ховд		16	35	72	30	38	2	193	96,472
17.	Хөвсгөл	22	20	28	94	14	6	2	186	97,277
18.	Хэнтий	21		34	49	15			119	84,790
19.	Дархан-Уул	19	3	17	78	20	35	2	174	77,652
20.	Орхон	21		19	50	19	1	2	112	70,712

21.	Говьсүмбэр	8	2	6	10				26	25,860
22.	Багануур	15	3	23	13		5		59	49,845
23.	Багахангай	2		7	9		8		18	33,169
24.	Баянгол	47	2	33	132		33	1	248	162,947
25.	Баянзүрх	64	48	15	235	24	43	4	433	233,590
26.	Сонгинохайрхан	65	15	77	239	49	74	1	520	219,665
27.	Сүхбаатар	35		33	160		13	3	244	147,850
28.	Хан-Уул	45		32	168		8	1	254	126,894
29.	Чингэлтэй	42	19	45		180	24	4	313	157,280
30.	Налайх	21		25	77		23		146	66,851
31.	Нийслэл					357			357	86,219
32.	ХХҮЕГ							202	202	1,043,414
33.	Бүгд	711	134	688	2279	912	656	237	5617	3,647,059

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг 2019 онд хэрэгжүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолоор баталсан. Уг хөтөлбөрийг 2019 хэрэгжүүлэхэд зарцуулах төсвийг 4,230.1 сая төгрөг буюу 2018 оны гүйцэтгэлээс 583.0 сая төгрөг буюу 16 хувиар нэмэгдүүлсэн бөгөөд доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөдөлмөрт бэлтгэх - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох болон нийгэмшүүлэх, ажлын байр, үйлдвэрлэлийн орчинтой танилцуулах, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагааны анхан шатны мэдлэг олгох, зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах багц үйлчилгээг үзүүлнэ.
- Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах - Шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтийг харгалзан хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулах, ажлын ярилцлагад ороход туслах, ажлын байр, ажил олгогчтой танилцуулах зорилгоор хөтөч, дохионы хэлмэрч ажиллуулна.
- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ - 5.0 хүртэл сая төгрөгийн дэмжлэгийг 4 хүртэл жилийн хугацаанд 100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгээр олгоно.
- Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ - Бичил бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтэд үндэслэн боловсруулсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх болон ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамруулна.
- Аж ахуй эрхлэлтийн сургалт - Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан болон бичил бизнес эрхэлдэг, цаашид эрхлэх хүсэл сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хүсэлтийн дагуу хамруулна.
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт - Эрх бүхий мэргэшсэн, боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн байгууллагаар тусгайлсан сургалтын хөтөлбөрт суурилсан хэлбэрээр хөгжлийн бэрхшээлтэй

- иргэнд 1-10 сарын хугацаанд багтаан мэргэжлийн ур чадвар, чадамж олгоно.
- Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтвортой буюу 12 сараас дээш хугацаагаар байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх урамшууллыг олгоно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар:

Хуульд нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байсан бөгөөд хуулийн хэд хэдэн бүлгийн зохицуулалтад өөрчлөлт оруулахад бүтэц, уялдаа нь алдагдахад хүрэх тул хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулж байна.

Хуулийн төслийн зорилго нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг боловсронгуй болгоход оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн дэргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг тодорхойлох дэд ажлын хэсгийг 2018 оны А/140 дугаар тушаалаар байгуулсан.

Хуулийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлуулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар тусгайлан нэг бүлэг оруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/140 дугаар тушаалаар дэд ажлын хэсгийг байгуулаад байна.

Уг хуулийн ерөнхий бүтэц:

- Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт Нийтлэг үндэслэл;
- Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ;
- Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ;
- **Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа;**
- Хуулийн төслийн тавдугаар бүлэгт Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээлэл;
- Хуулийн төслийн зургаадугаар бүлэгт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;
- Хуулийн төслийн долоодугаар бүлэгт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт;
- Хуулийн төслийн наймдугаар бүлэгт Бусад зүйлийн талаар зохицуулна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/276 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус хөтөлбөрийн сүүлийн 3 жилийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг 2018 оны 10 дугаар сарын 10-аас 11 дүгээр сарын 20-ны өдрүүдэд Улаанбаатар хотын 9 дүүрэгт дараах байгууллага, иргэдийг хамруулан зохион байгуулав. Үүнд:

- Тохируулгатай ажлын байр бий болгох зорилгоор санхүүгийн дэмжлэг авсан нийт 101 байгууллага
- Аж ахуй эрхлэлтийн болон мэргэжил олгох сургалт явуулсан 12 байгууллага
- Урамшуулалд хамрагдсан 63 байгууллага
- Дүүргийн хэмжээнд эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг авсан 81 иргэн
- Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэгт хамрагдсан 63 иргэн

Сүүлийн 3 жилийн хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт нийт 10.982.093.4 төгрөг зарцуулан 14986 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг уг хөтөлбөрт хамруулахаар төлөвлөсөн байна. Энэ хүрээнд 8721 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг мэдлэг, ур чадварыг олгох сургалтад, 6265 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байртай болгоход хөтөлбөрийн зорилт, төсөв чиглэгдсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас гаргасан гүйцэтгэлийн мэдээллээр 2016-2018 онд тухайн хөтөлбөрт нийт 14252 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсанаас 8843 иргэнийг сургалтанд хамруулж, 5409 иргэнийг ажлын байртай болгосон байна.

Хэдийгээр тус мэдээллээр сүүлийн 3 жилд 11674 ажлын байр бий болгосон, болгоход дэмжлэг үзүүлсэн дүр зураг харагдаж байгаа боловч Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо буурсан үзүүлэлттэй байгаа нь тус хөтөлбөрийн үр нөлөө хангалтгүй байгааг харуулахын зэрэгцээ хөтөлбөрийн 5.2.1, 5.2.2-т заасан үр дүн хангагдахгүй байна гэсэн дүгнэлт гарч байна.

Тус ажлын үр дүнд зөвлөмж гарган, Хяналт-шинжилгээ, үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/03 дугаар тушаалаар батлан холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

Мэргэжлийн боловсрол, сургалт

Монгол Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилийн эхэнд мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрөлтэй 86 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгаагаас 83 нь үйл ажиллагаа явуулж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын 50 байгууллага нь төрийн өмчийн, 36 байгууллага нь төрийн бус өмчийнх байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 2018-2019 оны хичээлийн жилийн эхэнд нийт суралцагчид 37039 байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 555, үүнээс эмэгтэй суралцагч 247 байна.

Хөгжлийн бэрхшээлийн ангиллаар авч үзвэл харааны бэрхшээлтэй 235 суралцагч байгаа бөгөөд үүнээс эмэгтэй 108 суралцагч, ярианы бэрхшээлтэй 58, үүнээс эмэгтэй 21 суралцагч, сонсголын бэрхшээлтэй 81, үүнээс эмэгтэй 37 суралцагч, хөдөлгөөний бэрхшээлтэй 102, үүнээс эмэгтэй 43 суралцагч, сэтгэцийн бэрхшээлтэй 35, үүнээс эмэгтэй 17 суралцагч, бусад төрлийн бэрхшээлтэй суралцагч 44 байна.

Хүснэгт 10. 2018-2019 оны хичээлийн жилд суралцах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл

Д/д	Бэрхшээлийн хэлбэр	Нийт	Эмэгтэй
1.	Хараа	235	108
2.	Сонсгол	81	37
3.	Яриа	58	21
4.	Хөдөлгөөн	102	43
5.	Сэтгэц	35	17
6.	Бусад	44	21
7.	Нийт	555	247

Энэ хуулийн хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилго, бүтэц, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг тусгасан байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын бүтэц, бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүд хамаарах ба хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авъяас, сонирхолд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролыг шинэчлэн хөгжүүлж, чанар, хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэх зорилготой.

Энэхүү хөтөлбөрт мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн

бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийг хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер, техникийн ажилтны түвшинд чадваржуулах, сургалтын нөхцөлийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгасан.

Хөтөлбөрийн 4.4.4 дүгээр заалтад хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэсэгт “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсрол, сургалтад тэгш хамруулах боломжийг нэмэгдүүлэх” талаар мөн тусгасан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд суралцаж байгаа зарим төрийн өмчийн болон төрийн бус өмчийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн танилцуулга:

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Мэргэжлийн ур чадвар олгох сургууль

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн боловсрол олгож, тэдэнд харилцаа, амьдрах ухаан, бизнес аж ахуй эрхлэх, англи хэл, биеийн тамир, эрүүл мэндийн болон мэргэжлийн технологийн хичээлүүдийг онол /20 хувь/ дадлага /80 хувь/ хослуулан заадаг. Бусад мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдээс ялгаатай нь боловсролын түвшин хамаарахгүй сургуулиас завсардсан болон суурь боловсролгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн боловсрол, чиг баримжаа олгож байна.

Тус сургуульд 1-2.5 жил суралцаж Тогооч, Талх, нарийн боов үйлдвэрлэлийн технологийн ажилтан, Оёмол бүтээгдэхүүний оёдолчин, Модон эдлэлийн мужаан, Бэлэг дурсгалын зүйл урлаач, Хэвлэлийн дизайнер, Гар утас, телефон аппаратны засварчин гэсэн 7 чиглэлээр мэргэжлийн боловсрол олгож байна.

Сургалтын орчин нөхцөл

Нийт 20-25 хүний багтаамжтай дотуур байртай, 16-45 насны жилд 90-120 хүртэлх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авч сургах хүчин чадалтай. Анги дүүргэлт 8-12 хүнтэй, 20 хүртэлх хувь хөгжлийн бэрхшээлгүй иргэд суралцах боломжтой.

Нэг сар хүртэлх богино хугацааны ур чадвар олгох сургалтыг нийслэл, дүүрэг, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдтэй хамтран явуулдаг.

Мөн сонсголын бэрхшээлтэй иргэдтэй хамтран, төрийн болон төрийн бус байгууллагуудад дохионы анхан шатны /багш, нийгмийн ажилтнуудад/ болон хэлмэрч, орчуулагчийн сургалтыг зохион байгуулдаг.



СЗСҮТ-ийн дотуур байр



Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль 2018-2019 оны хичээлийн жилд харилцаа холбоо, хүнсний үйлдвэрлэл, иргэний барилга байгууламж, үйлчилгээ, гар урлаач, дизайнч, хөнгөн үйлдвэрлэл гэсэн мэргэжлийн чиглэлүүдээр доор дурдсан хугацаа, мэргэжлээр нийт 139 суралцагч суралцаж байгаагаас 70 нь эмэгтэй суралцагч байна. Нийт 139 суралцагчаас 101 суралцагч нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна.

Хүснэгт 11. МБУЧОС-д 2014-2019 онд суралцсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл

№	Хичээлийн жил	Суралцагчдын тоо
1	2014-2015	85
2	2015-2016	65
3	2016-2017	69
4	2017-2018	116
5	2018-2019	139
	Нийт	474

Хүснэгт 12. 2018-2019 оны хичээлийн жилд суралцагчдын мэдээлэл

№	Мэргэжлийн чиглэл	Суралцагчдын тоо
1 жилийн анги		
1	Гар утас, телефон аппаратны засварчин	12
2	Бэлэг дурсгалын зүйл урлаач	13
3	Модон эдлэлийн мужаан	10
4	Талх, нарийн боов үйлдвэрлэлийн технологийн ажилтан	7
5	Тогооч	13
6	Киттельчин	19
2.5 жилийн анги		
1	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	20
2	Сийлбэрчин	11
3	Хэвлэлийн график дизайны анги	28
4	Сүлжмэлийн үйлдвэрлэлийн технологийн ажилтан	6
Суралцагчдын нийт тоо		139

Хараагүй иргэдийн холбооны мэргэжлийн сургалтын төв

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны дэргэдэх мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2015 оны 8 дугаар сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Монгол Улсын хэмжээнд харааны улмаас хөдөлмөрийн чадвараа 50 буюу түүнээс дээш хувиар алдсан харааны бэрхшээлтэй иргэдэд дараах үндсэн 7 мэргэжлийг олгож байна.

- Эмчилгээний бариа засалч – 2 жил
- Алжаал тайлах бариа засалч -1 жил
- Хүртээмжит технологийн мэргэжилтэн -2 жил
- Бэлэг дурсгалын зүйл урлаач -2 жил
- Ардын гоцлол хөгжимчин - / Морин хуур, Хөөмий / -2 жил
- Эстрадын хөгжимчин - / Даралтат хөгжимчин / -1 жил
- Кофе бэлтгэгч – / 1 жил / Бариста – аар боловсрол олгодог байгууллага юм.

Тус төв нь 36 хүн хүлээн авах хүчин чадал бүхий дотуур байртай бөгөөд хөдөө орон нутгийн суралцагчдыг дотуур байранд байрлуулдаг болно.



Алхах сургалт



Массажны өрөө

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсролд хамруулах боломжийг өргөжүүлэхийн тул дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

- Сургалтанд ашиглагдаж буй ном сурах бичгийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй хэлбэрээр сайжруулах /аудио, видео, DVD, брайль, дүрс зурган өгүүлэмжтэй/;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээл, сэргээн засал судлал, тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлыг судалж, мэдээллийн сан үүсгэх;
- Их, дээд сургуулиудад хөгжлийн бэрхшээлийн талаар нөлөөллийн сургалт зохион байгуулах;
- Төвийн бүсийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах сургалтын чиглэлээр сургалт зохион байгуулах;
- Сургалтын төлөвлөгөөний дагуу “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр”-ийг сургуулийн онцлогт нийцүүлэн сайжруулан боловсруулах;
- Төгсөгчдийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийн үйл ажиллагааг сайжруулах.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ: ЭРҮҮЛ МЭНД

Монгол Улсын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд сэргээн засах болон сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг нэмэлтээр тусгасан. Дээрх хуулийг дагалдан Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй эрүүл мэндийн байгууллагуудын бүтцийг шинээр бий болгосон. Тухайлбал, сэргээн засах төв, сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвүүдийн бүтэц, үйл ажиллагааны стандартын төслийг шинээр боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Хан-Уул дүүрэгт Хт 35 ортой сэргээн засах төв байгуулахаар 2019 оны улсын төсөвт /Эрүүл мэндийн сайдын багц/ 3 тэрбум төгрөг батлагдсан.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2018 оны А/69/48 дугаар тушаалаар “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт, Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг үнэлэх шалгуур, үзүүлэлт, Байнгын асаргаа шаардлагатай иргэн, хүүхдийг тодорхойлох заавар, Байнгын асаргаа шаардлагатай иргэн, хүүхдийн тодорхойлолт маяг”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.2.9 дэх заалтанд шинээр төрсөн нярай бүрийг 4 төрлийн тандалт шинжилгээнд (нярайн түнхний хэт авиан скрининг, нярайн сонсголын скрининг, дутуу нярайн ретинопатийн скрининг, бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийн скрининг) хамруулахаар заасан. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь нярайн тандалт шинжилгээний иж бүрэн аргыг эрүүл мэндийн тогтолцоонд үе шаттайгаар, бүрэн нэвтрүүлснээр нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах, хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэхэд оршиж байгаа юм.

2018 оны 8 дугаар сарын байдлаар нийт **308'254** шинээр мэндэлсэн нярайг түнхний хэт авиан скрининг оношилгоонд хамруулж, **4'647** нярайг мэс заслын бус аргаар эмчилж, тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлж чадсан. Дутуу нярайн ретинопатийн спрининг оношилгоонд нийт **4413** нярай хамрагдаж, **213** хүүхэд эмчилгээнд хамрагдаж, сохролоос сэргийлсэн. Нярайн сонсголын эмгэгийн скрининг оношилгоонд нийт **59'155** нярай хамрагдаж, **263** хүүхэд эмчлэгдэн дүлийрлээс сэргийлсэн.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 10 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх хүүхдийн зайлшгүй

шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г шинэчлэн баталлаа.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 11 дүгээр д тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн зардлыг санхүүжүүлэх, хяналт тавих журам”, “Эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн жагсаалт, түүний жишиг үнэ, даатгалын сангаас олгох төлбөрийн хэмжээ”-г шинэчлэн баталсан.

ДОЛООДУГААР БҮЛЭГ: БОЛОВСРОЛ

Хүснэгт 13. Боловсролын салбарт 2018 онд шинээр батлагдсан эрх зүйн баримт бичгүүд

№	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй холбоотой эрх зүйн баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Дугаар
Хамтарсан тушаал			
1	“Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг баталсан. Тушаалын хавсралтын 5-д “Ерөнхий боловсролын тусгай сургууль үйл ажиллагааны онцлогоос хамаарч Бага, дунд боловсролын тухай хуулийн 13.6-д заасан шаардлага болон бодит хэрэгцээндээ нийцүүлж жишиг нормативт заасан орон тоог 5 хүртэл тоогоор нэмэгдүүлж болно” гэсэн заалт орсон.	2018.01.23	A/024 A/11
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал			
1	Үлгэрчилсэн загвар, аргачлал батлах тухай. (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зохих түвшний боловсрол эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тухайн хүүхдийн хөгжлийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн уян хатан байдлаар сургах зорилгоор “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”-г нэгдүгээр, төлөвлөгөө боловсруулах аргачлалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсан)	2018.03.29	A/155
2	Ерөнхий боловсролын оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, оюуны хөгжлийн бэрхшээлтэй ахлах ангийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөөг тус тус шинэчлэн баталсан.	2018.08.06	A/491
3	29 дүгээр сургуулийн бага боловсролын Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийг баталсан.	2018.08.06	A/492
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг их, дээд сургуульд элсүүлэх бодлогын хүрээнд өмчийн хэлбэр харгалзахгүй дээд боловсролын сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг суралцах боломж, эрхийг бүрэн хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, тэднийг хөгжүүлэх,	2018.05.04	A/261

	ажилд зуучлах, албан хаагч ажиллуулах, дээд боловсролын сургалтын байгууллага нь 300-аас дээш оюутантай тохиолдолд орон тооны, 300-аас доош оюутантай тохиололд хавсран гүйцэтгүүлэх шийдвэр гарсан.		
5	“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг хөгжлийн ахицаар үнэлэхээр тусган баталсан.	2018.06.29	A/425
6	“Аюулгүй амьдрах ухаан “ сургалтын хөтөлбөр батлагдсан.	2018.04.06	A/181
7	“Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам” баталсан.	2018.04.05	A/168
8	“Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”-ийг баталсан.	2018.05.01	A/243


Хамран сургалт

Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1,087 хүүхэд цэцэрлэгт, 6,518 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд тус тус суралцаж байна.

Хүснэгт 14. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалт

№	Насны ангилал	Бүх хүүхдийн тоо	Боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	Хувь
1	2-5 настай	1.900	1.087	57.2
2	6-18 нас	8.351	6.518	78
3	Бүгд	10.251	7.605	67.6


Зураг 2. Цэцэрлэг, сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо



Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах үйл явцыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Тэгш хамран сургалтыг дэмжих хүрээнд Жайка “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” 4 тусгай, 8 ердийн сургуульд хэрэгжиж байна.

Зураг 3. “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн зорилтот аймаг, дүүрэг



НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Тэгш хамран сургалттай, эрүүл чанартай сургалтын орчин” төслийг 6 сургууль дээр хэрэгжүүлж, 90 гаруй суралцагч, 550 гаруй иргэдийг хамруулсан үйл ажиллагааг зохион байгуулсан.

Төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ерөнхий боловсролын сургалтад хамрагдах үед тохиолдож болзошгүй саад бэрхшээлийг даван туулахад туслах зориултаар харилцааны хялбар хэрэгсэл болох “Найз” аппликейшн бүтээсэн.

Тус аппликейшн нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад суралцагчидтай шууд харьцах, тэднээс тусламж дэмжлэг хүсэх зэрэг тэдний анхан шатны болон зарим чухал хэрэгцээтэй үед хэрэглэгдэх 85 үг, хэллэгийг оруулсанаас гадна хүүхэд өөрт хэрэгтэй үгс, өөрийн хүссэн дүрс, дуу хоолойг энэ апплекэйшинд нэмж оруулах боломжтой юм.

- Баянхонгор аймаг: Эрдэм ахлах сургууль-14
- Заг сумын 9 жилийн сургууль-4
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв-154
- Говь-Алтай аймаг: 3-р сургууль-17
- Баян-Уул сумын ЕБС-27
- Завхан аймаг: 4-р сургууль-12
- Шилүүстэй сумын ЕБС-8

Энэ хичээлийн жил ерөнхий боловсролын тусгай сургуулийн 2 сурах бичиг, 1 багшийн номыг **103,479,600** төгрөгийн санхүүжилтээр улсын төсвөөс хэвлэн сургалтад ашиглаж байна..

- Монгол хэл I (Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын)
- Математик V (Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын)
- Хэл засал I-V (Сонсголын бэрхшээлтэй сурагчдын багшийн ном)

Сургуульд хамрагдахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

1. Дүйцсэн хөтөлбөрийн сургалт:

2018-2019 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 355 насан туршийн боловсролын төв үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрт нийт 7296 суралцагч хамрагдаж байгаагийн 12,8 хувь буюу 933 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт суралцагчдын 42,1 хувь буюу 393 нь бага боловсрол, 47,2 хувь буюу 440 нь суурь боловсрол, 10,7 хувь буюу 100 нь бүрэн дунд боловсролын түвшинд суралцаж байна.

2. Гэр сургалт:

Хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэрээр сургах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд 8 аймаг, 2 дүүргийн Насан туршийн боловсролын төвүүдэд зохион байгуулж байна. Уг сургалтад нийт 131 хүүхэд хамрагдаж байгаагийн 55 хувь буюу 72 нь эрэгтэй, 45 хувь буюу 59 нь эмэгтэй байна.

Хүснэгт 15. Гэр сургалтад хамрагдалт, аймаг, дүүргээр

№	Аймаг, дүүрэг	Суралцагчийн тоо
1	Баянхонгор	6
2	Баян-Өлгий	5
3	Говь-Алтай	5
4	Дархан-Уул	11
5	Завхан	25
6	Сэлэнгэ	13
7	Сүхбаатар	6
8	Төв	38
9	Баянзүрх	8
10	Налайх	14
	Нийт	131

Хүснэгт 1. Сургалтад хамрагдаж буй нийт суралцагчийн тоо /аймаг, дүүргээр/




График 1. Нийт суралцагчдын тоо /насны ангиллаар/

3. Багш, боловсон хүчнийг чадавхжуулах сургалт:

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй насан туршийн боловсролын багш нарыг чадавхжуулах зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадавх бэхжүүлэх нь” 2, 3 дахь шатны сургалтыг 2018 оны 5, 12 дугаар сард зохион байгууллаа.

Хүснэгт 16. Багш, ажилчдыг чадавхжуулсан сургалт

№	Сургалтын нэр	Зохион байгуулагдсан газар	Хугацаа	Зорилтот бүлэг	Хамрагдсан хүний тоо
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадавх бэхжүүлэх нь /2, 3 дахь шат/	БЗД-ийн НТБТ	V/17-18 XII/10-11	БЗД-ийн НТБ-ын багш, арга зүйч, захирал, БГД, ЧД, ХУД, СХД, СБД-ийн багш, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч нар	66

Тусгай хэрэгцээт боловсролын багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ

Тусгай сургуулийн эмч нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг Оросын холбооны улсын Чита мужийн Эрхүү хотын “Сэргээн засах төв”-д зохион байгууллаа. Сургалтад 6 сургуулийн эмч хамрагдаж, шаардагдах зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам шийдвэрлэсэн.

"2018-2019 оны хичээлийн жилд Оросын холбооны улсад "Тусгай хэрэгцээт боловсролын багш" мэргэжлээр суралцах 10 оюутныг Оросын холбооны улсын Эрхүү хотын Байгалийн их сургуульд суралцуулж байна "

Монгол Улсын Боловсролын их сургуульд 2018 онд “Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим”-ийг байгуулсан. Тусгай хэрэгцээт боловсролын багшийн ангид нийт 96 оюутан суралцаж байна. Суралцаж буй оюутнууд сонгон судлахаар “Дохионы хэл” 2 кр/цаг, “Сонсголын болон харааны бэрхшээлтэй хүүхдийн боловсрол” хичээлийг 3 кр/цагаар судалж байна. Оюутнууд тусгай сургуульд 4 долоо хоног хоног туршин заах дадлага хийж байна.6

Түүнчлэн МУБИС-ийн Боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль, Байгалийн ухааны сургуулийн багш мэргэжлийн ангийн оюутнууд “Тусгай хэрэгцээт боловсролын үндэс”, “Тэгш хамруулан сургах боловсрол” хичээлүүдийг 2 кр/цагаар сонгон болон заавал судлах хэлбэрээр судалж байна. Тухайлбал, энэ хичээлийн жилд Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль, Биеийн тамирын сургуулийн нийт 240 оюутан судалсан. Мөн “Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим”-ээс энэ хичээлийн жилд оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн туршин заах дадлага хийлээ. Тусгай сургуулийн багш нарын санал хүсэлт, хэрэгцээнд тулгуурлан нийт 26 багшийг хамруулсан “Хэл заслын үндэс” 3 кр/цагийн нэмэлт хөтөлбөр боловсруулж сургалт зохион байгууллаа.

Оросын холбооны улсын Эрхүү мужийн доктор, профессор Светлана Юрьевна урьж “Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалтыг Монгол Улсын 50 багш, судлаач, оюутнуудад 3 өдрийн турш зохион байгууллаа.

2018 онд Тусгай цэцэрлэг, сургуулийн багш ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтыг хараа, сонсгол, оюуны бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг цэцэрлэг сургуулийн багш, туслах багш, сургуулийн удирдах болон сургалтыг дэмжих ажилтны гэсэн 5 зорилтод бүлэг 9 ээлж 14 бүлгээр тус бүр 3 хоног үргэлжилсэн мэргэжил дээшлүүлэх сургалтыг улсын төсвийн 17.5 сая төгрөгний санхүүжилтээр зохион байгуулж нийт 392 хүнийг хамрууллаа.

Хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарыг чадвахжуулах сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 116, 29 дүгээр сургуулийн тус бүр 25 багш, Өмнөговь, Хөвсгөл аймгуудаас тус бүр 1 багш, МУБИС-ийн тусгай боловсролоор

суралцаж байгаа 5 оюутан нийт 57 хүн хамрагдлаа. Харааны бэрхшээлтэй 3 багшид сургалтын гарын авлагыг брайлаар хэвлэж, сонсголын бэрхшээлтэй 5 багшид дохионы орчуулагчаар дамжуулан сургалтыг зохион байгуулсан. 2019 онд сургалтанд хамрагдсан дээрх багш нарт ахисан түвшний сургалтыг дахин зохион байгуулна.

Сургалтын орчинг сайжруулан дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

“Оюу толгой” ХХК-ний 140,0 сая төгрөгийн дэмжлэгээр ерөнхий боловсролын 25 дугаар сургуулийг зориулалтын лифт суурилуулж, тохижилт хийлээ.



Ерөнхий боловсролын 25, 55, 63, 70, 116 дугаар сургууль, 10, 186 дугаар цэцэрлэгт 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 тэрбум төгрөгний өртөгтэй автобусыг “Үүр тээл” ХХК эх орондоо угсарч хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.

Ерөнхий боловсролын 25, 55, 63, 70, 116 дугаар сургууль, 10, 186 дугаар цэцэрлэгт 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 500 сая төгрөгний тавилга, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн худалдан авсан.

Ерөнхий боловсролын 25, 55, 63, 70, 116 дугаар сургууль, 10, 186 дугаар цэцэрлэгт 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 500 сая төгрөгний их засварын ажил хийгдсэн.

Тусгай 10 дугаар цэцэрлэгийн санхүүжилт шийдэгдлээ. Монгол Улсад анх удаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 120 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын ажил эхэллээ. Санхүүжилт 4.9 тэрбум төгрөгөөр батлагдлаа.

Цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл

- Эцэг эхчүүдийг чадваржуулах ажлыг үе шаттай зохион байгуулах;
- Тусгай цэцэрлэгийн дүрэм боловсруулж, батлуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих “Хөгжлийн төв”-ийг аймаг бүрт байгуулах;

- Хүүхдийн хөгжлийн онцлог, суралцах чадамж, хэрэгцээ сонирхолд тулгуурлан засан сайжруулах хичээлийн хөтөлбөр боловсруулж, батлуулах;
- “Хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх үйлчилгээг зохион байгуулах журам”-ын төслийг боловсруулан батлуулах.

НАЙМДУГААР БҮЛЭГ: ХҮРТЭЭМЖ

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХҮРТЭЭМЖ

Холбогдох хууль тогтоомж

“Хот байгуулалтын тухай” хуулийн 20 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн талаар тусгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй үйлчлүүлэх орчин нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт, барилгажилтын шийдэл, зураг төсөл зэрэгт зөвшөөрөл олгохыг хориглосон байдаг.

Мөн барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шаардлагыг 15 дугаар зүйлд тусган хэрэгжүүлж байна.

Дараах норм, нормативын баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагын талаар тусган мөрдүүлж ажиллаж байна. Үүнд:

- “Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай” MNS 91.040.10: 2009 стандарт
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг тооцсон төлөвлөлт”
- “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайн төлөвлөлт” барилгын дүрэм
- “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт” БНБД
- “Сургалт хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох” заавар
- “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилгын технологийн зураг төсөл” барилгын дүрэм
- “Үр тариа хадгалах болон боловсруулах байгууламж” БНБД
- “Үйлдвэрийн газрын байгууламж” БНБД

- “Хот байгуулалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд “хот байгуулалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хангах зарчмыг баримтлах” талаар нэмж тусгаж, холбогдох заалтуудыг нарийвчлан боловсронгуй болгохоор ажиллаж байна.
- “Барилгын тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлуулж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангахтай холбоотой зүйл, заалтуудыг шинээр нэмж тусгасан. Хуулийг дагалдах дүрэм, журмын төслүүдийг боловсруулж байна.
- “Авто зогсоолын тухай” хуулийн төслийн 13 дугаар зүйл. Авто зогсоолд тавигдах нийтлэг шаардлагад 13.1.8. хөгжлийн бэрхшээлтэй иргэний авто тээврийн хэрэгсэлд зориулсан авто зогсоолын хэсгийг тогтоосон норм, дүрэм, стандартын дагуу байгуулсан байх;

- “Газрын төлбөрийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд газрын төлбөрөөс эхний 3 жилд 100 хувь, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө” гэж тус тус тусгаад байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит хуралдаанаар Хүртээмжийн тухай хуулийг боловсруулж энэ онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг тус яаманд үүрэг болгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 51 дүгээр тушаалаар дээрх хуулийн төсөл боловсруулах салбар дундын ажлын хэсгийг байгуулав.

Салбарын норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох ажлын хүрээнд Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04, Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн төлөвлөлт, Сургуулийн өмнөх боловсролын барилгын зураг төсөл төлөвлөх, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль БД 31-101-04 зэрэг норм, нормативын баримт бичгийг шинэчлэхээр 2018 оны төлөвлөгөөнд оруулж батлуулан ажиллаж байна.

2016 онд 511, 2017 онд 587, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 370 /орон сууц, оффис, үйлчилгээний, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, соёлын төв гэх мэт/ ажлын зураг төсөлд барилга архитектурын 46 орон тооны бус экспертүүдээр дамжуулан магадлал хийх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй, хэрэгцээ шаардлагад нийцсэн барилга байгууламжийн төлөвлөлтөд тавигдах шаардлага” нормативын баримт бичгүүдийг нийтэд сурталчлан таниулах анимейшн хийх ажлын техникийн даалгаврыг боловсруулж, 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдөр яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулаад байна.

Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд шинээр баригдах орон сууцны хотхон, хорооллын барилга байгууламжийн орц, гарцанд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан налуу зам төлөвлөх, цахилгаан шатанд брайль үсгэн тэмдэглэгээтэй товчлуур хийх, гадна авто машины зогсоолын 3 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоол төлөвлөх, хотхон, хорооллын доторх явган замыг хараагүй хүмүүст зориулсан товгор гадаргуутай хавтангаар хийх, барилга байгууламжийн 1-р давхрын коридорын хананд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бариул зэргийг төлөвлөх түүнийг төлөвлөсөн зургийн дагуу гүйцэтгэх зэрэг ажлыг байнга тогтмол хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26

дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах” журманд хөгжлийн бэрхшээлтэй иргэний түрээсийн квотыг хотод болон орон нутагт 5 хувь байхаар тооцож тусгасан бөгөөд өнгөрсөн хугацаанд нийтдээ 510 орон сууцыг түрээслэснээс 98 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан нь нийт түрээслэгчийн 6.5 хувийг эзэлж байна.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.77.1-д заасан “Орон сууц” үндэсний хөтөлбөрийн болон уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 85 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагын төлөөлөл ажиллаж байна. Энэхүү үндэсний хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг түрээсийн болон халамжийн орон сууцанд хамруулах талаар тусган холбогдох газруудаас санал авч Засгийн газрын хуралдаанаар оруулахаар бэлтгэж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 184 дугаар тушаалаар Сайдын зөвлөлийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллагуудын төлөөлөл болгож “Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо” төрийн бус байгууллагын тэргүүнийг оруулан ажиллаж байна.

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхтэй холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд, нийслэл болон аймгуудын Засаг дарга нартай 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр байгуулсан гэрээнд нийслэл, аймаг дахь нийтийн зориулалттай бүх барилга байгууламжуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй эсэхэд хийх үзлэгийг ашиглагдаж байгаа барилга байгууламжийн газар хөдлөлтийн үйлчлэлд тэсвэрлэх чадварыг үнэлэх, паспортжуулах ажилтай хамтран хийж нэгдсэн дүн мэдээг ирүүлэх, хүртээмжтэй болгох асуудлаар дүгнэлт гаргаж хэрэгжүүлэх ажлыг тусган хагас, бүтэн жилээр тайланг авч ажиллаж байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

- Нийслэл болон орон нутаг дахь нийтийн зориулалттай бүх барилга байгууламжуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгоход анхаарах;
- Салбарын норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох ажлын хүрээнд 2018 онд эхлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг хангахад чиглэсэн норм, нормативын баримт бичгийг шинэчилж дуусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

ЗАМ, ТАЛБАЙН ХҮРТЭЭМЖ

Хот суурин газрын төлбөр хураах цэгүүд Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тээврийн хэрэгслийг авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлнө” гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний тээврийн хэрэгслийг авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлж, уг хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хөтөлбөрт “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан зам, техникийн шаардлага” MNS 6056:2009, “Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009 улсын стандартуудыг шинэчлэн боловсруулах ажил тусгагдсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу зөвлөх үйлчилгээний тендерийг 2018 оны 3 дугаар сард гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж “Геозураглал” ХХК-тай 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 2018/283 тоот гэрээ байгуулан дээрх стандартуудыг 2019 оны 5 дугаар сард багтаан батлуулахаар ажиллаж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд “Иргэний барилга, зам, замын байгууламж, нийтийн тээврийн холбогдох стандартыг үнэлэх, шинэчлэх” зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Улсын үзлэг явуулах тухай” тушаалаар Зам, тээврийн хэмжээнд мөрдөгдөж буй үндэсний стандартын баримт бичгийн үзлэгийг зохион байгуулах салбар комисс байгуулагдан ажилласан.

Энэхүү стандартын улсын үзлэгээр “Үндэсний стандартууд хэрэглэгчдийн шаардлага хэрхэн хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, тендерийн баримт бичиг болон бусад техникийн баримт бичгүүдэд хэрхэн тусгагдаж, бусад баримт бичгүүдтэй хэрхэн уялдаж байгаа талаар үнэлгээ өгөх, шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох стандартуудын жагсаалт гаргаж, цаашдын ажлын төлөвлөгөөнд тусгаж байх” гэсэн дүгнэлт, зөвлөмж гарган ажилласан.

МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ

_____Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолын “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025”-ын 3.4.5 дэх хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилт тусгасан.

Монгол Улсад радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн хөгжлийг дэмжих, зах зээлийн

өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, нийтийн ашиг сонирхолд нийцсэн, чанартай үйлчилгээгээр олон нийтийг хүртээмжтэй хангахад чиглэсэн харилцааг зохицуулах зорилгоор боловсруулагдаж буй Өргөн нэвтрүүлгийн хуулийн төслийн “23-р зүйл. Хөтөлбөрт тавигдах ерөнхий шаардлага” хэсэгт сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан зэрэгцээ бичгэн барилт, дохионы хэлний орчуулгатай нэвтрүүлэг нэвтрүүлэх тухай заалтыг тусгасан.

Тоон телевизийн үндэсний сүлжээгээр дамжуулах өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлагыг боловсруулахдаа сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы хэл, текстэн тайлбар бүхий мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, кино, хүүхдэд зориулсан кино, нэвтрүүлэг гаргах үүрэгтэй ба үүний дагуу төлөвлөлт гаргасан байх тухай заалтыг тусгахаар ажиллаж байна.

Стандарт хэмжил зүйн газраас төрийн байгууллагуудын веб сайтуудад тавигдах стандартыг Харилцаа холбооны зохицуулах хорооны төлөвлөгөөнд шинэчлэх, шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд төрийн байгууллагын вебсайт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх талаарх заалтыг тусгахаар ажиллаж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын хурал зохион байгуулагдлаа

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран Улаанбаатар хотноо Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлыг өнгөрсөн 2018 оны 07 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Энэ хурлын үеэр гамшигт тэсвэртэй дэд бүтцийг бий болгох, нийгмийн эмзэг буюу зорилтот бүлгийн хэрэгцээ шаардлагыг хангасан гамшгаас хамгаалах тогтолцоог хөгжүүлэх, тэдний оролцоо, манлайллыг хангах гэх зэрэг олон чухал асуудлыг хөндсөн юм. Хуралд олон улс, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн байгууллага болон хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрдэмтэн судлаачид зэрэг 50 гаруй орны 3000 гаруй зочид төлөөлөгчид оролцсон байна.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: ЯАМДЫН ДЭРГЭДЭХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ОНЦЛОХ АЖЛУУД**

**Хүснэгт 17. Яамдын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд
зөвлөлийн бүрэлдэхүүн**

Д/д	Яамны нэр	Нийт гишүүдийн тоо	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага
1.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	25	15	10
2.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	18	10	8
3.	Барилга, хот байгуулалтын яам	26	18	8
4.	Батлан хамгаалах яам	11	8	3
5.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	27	19	8
6.	Гадаад харилцааны яам	9	8	1
7.	Зам, тээврийн хөгжлийн яам	18	14	4
8.	Сангийн яам	14	7	7
9.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	17	10	7
10.	Хууль зүй, дотоод хэргийн яам	17	14	3
11.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	16	11	5
12.	Эрүүл мэндийн яам	24	17	7
13.	Эрчим хүчний яам	16	8	8
14.	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	24	14	6 ААНБ-4

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний хүний эрхийг хангах дэд зөвлөл 2018 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Үүнд:

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулаад байна. Энэ хүрээнд хуулийн хэрэгжилтийн талаарх үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг нэгтгэн боловсрууллаа. Мөн хуулийн хүрээнд үйлчилгээ авч буй иргэд, үйлчилгээ үзүүлэгч төв, орон нутгийн төрийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөс хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагын талаар тусгайлсан судалгаа хийлээ. Эдгээр ажлын үр дүнд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу тандан судалгаа хийж, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдтай хамтран батлуулахаар төслийг тус яамдад хүргүүлээд байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 2, 3 дугаар нэгтгэсэн тайлан бичих ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/231 тоот тушаалаар байгуулсан. Нэгдсэн үндэстний байгууллагаас конвенцийн тайлан бичих арга, аргачлалд өөрчлөлт оруулж, тухайн орны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагуудын сүүдэр илтгэлийн дагуу Засгийн газарт хандсан асуумжуудыг илгээдэг болсон. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газарт 2018 оны 10 дугаар сард асуултыг ирүүлсэн бөгөөд асуултын дагуу мэдээлэл тайланг авахаар холбогдох яамд байгууллагуудад хүргүүлсэн. Тайланг НҮБ-д ирэх оны 10 дугаар сарын 01-ний дотор хүргүүлэхээр ажиллаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй оны шилдгүүдийг шалгаруулах шалгуур, журмын төслийг боловсруулсан бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. 2019 оны эхний хагас жилд энэхүү үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 23.3-д заасан Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний стандартын төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг стандартын төслийг боловсруулан 2018 оны 12 дугаар сард Нийгмийн хамгаалал, халамжийн стандартчлалын техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулав. 2019 онд стандартыг хэрэгжүүлэх удирдамж, зааврыг салбар бүрт батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Төрийн байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл хэрхэн хэрэгжиж байгаа талаарх мэдээллийг бүх салбараас цуглуулан дүгнэлт хийлээ.

Салбар бүрт хэрэгжилт хангалтгүй байна. Нийт 9 яамдаас 222 байгууллагын мэдээлэл ирүүлсэн бөгөөд 44609 хүн ажиллаж байгаагаас 1782 хүн хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байна. Манай яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт тус хуулийн заалтын хэрэгжилт, төлбөрөө төлж буй байгууллагуудын мэдээлэл цуглуулан судлагаа хийсэн бөгөөд дүнгээ танилцуулсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт салбаруудад хэрхэн хэрэгжиж буйг эргэн харах хэрэгтэй байна. Тус хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хангаж ажиллах шаардлага бүх салбарт байна. Тиймээс дахин мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах Ази, номхон далайн бүсийн 4 дүгээр Конгрессыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын 107 дугаар захирамжаар байгууллаа. Ази, Номхон далайн сэргээн засах сүлжээтэй хамтран 2019 оны конгрессын бэлтгэл хурлыг 2018 оны 06 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Хурлаар конгрессын бүтэц, үндсэн сэдэв, дэд сэдэв, зохион байгуулах огноо, зохион байгуулах газрын байршил, хөтөлбөр, төсөв, бүс нутаг, Монгол Улс дахь олон улсын байгууллагын хамтын ажиллагаа зэрэг асуудлыг хэлэлцлээ. Мөн Монгол Улсын Засгийн газар болон Ази, номхон далайн бүсийн сүлжээ хооронд конгресс зохион байгуулах асуудлаар Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, бэлтгэлийг хангаж байна.
- Ази, Номхон далайн бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах 4 дүгээр конгрессыг зохион байгуулах Үндэсний хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах салбар дундын ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/211 дугаар тушаалаар баталсан. Тус тушаалаар ажлын үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Конгрессын албан ёсны цахим хуудсыг ажиллуулж эхлээд байна. www.apcbid2019.mn
- Жайка байгууллагын “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх” төслийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг зохион байгуулах хөгжлийн бэрхшээлтэй 32 сургагч багшийг бэлтгэсэнээр эдгээр сургагч багш нартай хамтран 229 гаруй удаагийн сургалтыг зохион байгуулж, 7445 гаруй төрийн болон хувийн хэвшлийн ажилтан албан хаагчдыг хамруулж, тухайн сургалт зохион байгуулсан байгууллагынхаа орчныг сайжруулж, хүртээмжтэй болгоход анхаарч ажиллаж байна. Түүнчлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын харьяа 45 байгууллагад уг сургалтыг зохион байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санаачилгаар бүх яамдын салбарын ажиллагчдын ойлголт, хандлагыг өөрчлөх зорилгоор “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлүүдэд зохион байгуулж байна. Түүнчлэн уг сургалтыг 2018 онд дараах

байгууллагуудад зохион байгуулаад байна.

- Боловсролын салбарын Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн боловсролын газар, аймаг дүүргүүд дэх хүүхэд харах үйлчилгээний багш нар, их, дээд сургуулиуд, үйлчилгээний байгууллагууд, хөдөө орон нутаг, хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрүүд, төрийн бус байгууллагын ажиллагчдыг хамруулав. Цаашид Эрүүл мэндийн болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчдад төлөвлөгөөт хуваарын дагуу сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хариуцсан тогтолцоог бэхжүүлж, төв, орон нутгийн ажилтнуудыг чадавхжуулах хүрээнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэх санал боловсруулан Засгийн газрын 2018 оны 308 дугаар тогтоолоор батлуулсан. Салбар бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд анхаарал хандуулж, шинээр боловсруулж буй хууль тогтоомж, бодлого, хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг тусган, тухайн салбарын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн бус байгууллагууд оролцох боломжийг улам сайжруулснаараа ач холбогдолтой юм.
- Зүүн бүсийн аймгуудын хүн ам, гэр бүл, хүүхэд залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг Дорнод аймагт зохион байгууллаа. Сургалтаар хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хууль тогтоомжийг сурталчлах, ажилтнуудын хүн амын асуудлыг бусад салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, хяналт тавих чиглэлээр ойлголт, мэдлэгийг нь сайжруулж, хүн ам, хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын бодлого, үйл ажиллагааны талаар зөвлөмж, чиглэл өгсөн. Сургалтанд нийт 150 гаруй хүн оролцсон бөгөөд сургалтын үеэр Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвөөс Дорнод аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэнд, сэтгэл зүй, протез ортопед, мэргэжлийн сургалтын талаар зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүллээ.
- Аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, мэргэжилтнүүд зориулсан сургалтыг 12 дугаар сарын 4,5-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтаар хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээлэл өгч, санал бодлоо солилцсон юм.

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санаачилгаар “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг бүх яамдын дэд зөвлөлийн гишүүдэд болон тус яамны харьяа 45 байгууллагад зохион байгууллаа. Сургалтад хамрагдсанаар хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагад эерэгээр нөлөөлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, оролцоог хангах асуудлын бодлого, үйл ажиллагаандаа уялдуулах боломжтой болж байна.

Төр, төрийн бус байгууллагын түншлэлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааны хүрээнд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/93 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нийслэл дэх 37 байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй байдалд үнэлгээ хийх ажлыг 2018 оны 04 дүгээр сарын 23-наас 05 дугаар сарын 23-ны хооронд зохион байгууллаа. Энэхүү үнэлгээг Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, “Түгээмэл хөгжил”, “Сонгино” бие даан амьдрах төв гэсэн хүртээмжийн үнэлгээгээр мэргэшсэн төрийн бус байгууллагаар хийж гүйцэтгүүллээ. Үнэлгээний тайланг танилцуулах семинарыг 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын удирдлага, холбогдох мэргэжилтэн, яамдын дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга нар 80 гаруй хүн оролцлоо. Семинарын үр дүнд салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх ажлын төлөвлөгөө гарган, шаардлагатай хөрөнгийг үе шаттайгаар төсөвт тусгах, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах зэргээр орчны стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулахаар боллоо. Үнэлгээнд хамрагдсан нийт байгууллагад санал зөвлөмжийн дагуу ажиллах тухай чиглэлийг хүргүүлсэн.
- 2018 оны 2 дугаар сараас эхлэн сар бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулж ирлээ. 2018 онд нийт 7 удаагийн арга хэмжээг холбогдох төр, төрийн бус байгууллагуудын оролцоог ханган зохион байгуулсан. Мэдээллийн цагийн үеэр яамдын дэд зөвлөлийн үйл ажиллагаа, шинээр боловсруулж буй хууль тогтоомжийн төсөл, хэрэгжүүлж байгаа төсөл, үйл ажиллагааны талаар танилцууллаа.

02/28	<ul style="list-style-type: none"> •ХБХ-ий эрхийг хангах орон тооны зөвлөлийн хурлын мэдээлэл, зөвлөлийн 2018 оны тайлан, 2019 оны төлөвлөгөө •Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх эрх, оролцоо, хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл
703/29	<ul style="list-style-type: none"> •ХХААХҮЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн мэдээлэл •Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл •INSPIRED төслийн тухай танилцуулга

04/30	<ul style="list-style-type: none"> •ЭМЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн мэдээлэл •Эмнэлэг, хөдөлмөр, магадлах комиссын талаарх мэдээлэл •Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд хамруулах хөгжүүлэх стандартын төсөл
06/29	<ul style="list-style-type: none"> •БХБЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн мэдээлэл •Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тухай
09/25	<ul style="list-style-type: none"> •ХБИ-ийн мэдээллийн сан байгуулах улсын үзлэгийн ажлын тухай •АХБ-ны хөнгөлөлттэй зээлээ хэрэгжүүлж байгаа “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн тухай •Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын танилцуулга •Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй оны шилдгүүдийг шалгаруулах журмын төсөл
10/19	<ul style="list-style-type: none"> •Сангийн яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн мэдээлэл •Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга
12/19	<ul style="list-style-type: none"> •БСШУСЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн мэдээлэл •Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд БСШУСЯ-аас боловсруулж буй журмуудын төслийн танилцуулга

Төрийн бус байгууллагууд хууль тогтоомжийн шинэчлэл, арга хэмжээ үйл ажиллагааг цаг алдалгүй хүргэж байгаад нь талархалтай хандаж буйгаа илэрхийлж байгаа.

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилт:Олон улсын чиг хандлага” сэдэвт онол, практикийн хурлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хүрээнд зохион байгуулж, хурлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, тэдний талаарх эерэг ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, олон улсын туршлагын талаар хэлэлцэн, санал зөвлөмж гаргалаа. Хуралд төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөлөл нийт 70 гаруй хүнийг хамрууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар олон улсын туршлага, судалгаа шинжилгээний ажлын талаарх шинэлэг мэдээлэлтэй болсон төдийгүй Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлын талаар өөрсдийн санал бодлоо хуваалцсан юм. Хуралд хэлэлцүүлсэн итгэлүүдийг нэгтгэн эмхэтгэл болгон хэвлүүлээд байна. Энэхүү онол, практикийн хурлыг зохион байгуулснаар хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр ажиллаж байгаа төр, төрийн бус, олон улсын байгууллагууд цаг үеийн мэдээллээ солилцож, цаашид

анхаарах асуудлуудад анхаарал хандуулж, хамтран ажиллах хүрээгээ тодорхойлсон үйл явдал болсон.

- 2018 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 170 сая төгрөг зарцуулж, нийт 18 үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүний үр дүнд 1300 гаруй хүнд холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээллийг хүргэж, 1000 гаруй хүнийг урлаг соёлын арга хэмжээнд хамруулан, 60 байгууллагад хүртээмжийн үнэлгээ хийлээ. Монгол Улсад зохион байгуулагдсан “Дэлхийн хараагүйчүүдийн холбооны Ази, Номхон далайн бүсийн чуулган, Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Зүүн хойд Азийн бүс нутгийн VIII хурлыг зохион байгуулахад санхүү зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллалаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар тус яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан болно.

Зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

- Аялал жуулчлалын зориулалтаар тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулахаар хүсэлт гаргасан иргэн, аж ахуй нэгжийн барилгажилтын стандартад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангасан орц гарцны хүртээмжийн норм шаардлага тавьж барилгын стандартыг боловсруулан баталдаг холбогдох төрийн байгууллагуудаас тодорхой зөвлөмж авч, санал солилцон хамтран ажиллаж байгаа болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зорилтын хүрээнд аялал жуулчлалын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжих, тэдгээрийг байнгын орлогоор хангах чиглэлээр тус оператор, компаниудад болон жуулчны баазуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гар урлалын бүтээгдэхүүнийг жуулчдад худалдан борлуулах төлөвлөгөө гаргаж Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран ажиллахаар бэлтгэж байна. Түүнчлэн улсын хэмжээнд зохиогдож буй Аялал жуулчлалын арга хэмжээнүүдийн нэгдсэн хуваарь байршлын талаар мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагад хүргүүлсэн.
- Тус яам болон харьяа байгууллагуудын хэмжээнд нийт 54 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байна. Уг судалгаагаар хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, сүүлийн 2 жилд байгууллагаас үзүүлсэн тусламж дэмжлэгийн судалгааг авч, цаашид хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын тоог

- нэмэгдүүлэх арга хэмжээ авахаар холбогдох бэлтгэлийг ханган ажиллаж байна.
- Тус яамны Дэд зөвлөлийн зүгээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах төрийн бус байгууллагуудтай санал солилцсоны үндсэн дээр Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургалттай 10 жилийн 29, 31 дүгээр сургуулиуд дээр “Нэг сая мод” төрийн бус байгууллагын сургагч багш нартай хамтран сургалт зохион байгуулахаар гэрээ байгуулан ажиллаж байна.
 - Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны иргэн Д.Батсайханы өрхийн гар урлалын бизнесийг дэмжин 1 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг тус яамны зүгээс олгосон болно.
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орц, гарц, угтах үйлчилгээ, ариун цэврийн өрөөг стандартад нийцүүлэн ажиллах ажлын хүрээнд тус яамны 2019 оны төсөвт 30 /гучин сая/ төгрөгийг тусгаад байна.
 - Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцсон 21 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт, тус яамны тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын харьяа 33 хамгаалалтын захиргааны дарга нарт, Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Сав газрын удирдлагын хэлтсийн харьяа 21 сав газрын захиргааны дарга нарт болон Цаг уур, орчны шинжилгээний газрын удирдлагуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар мэдээлэл хийлээ.
 - Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/119 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хүрээнд Мэлхий хад орчимд авто зогсоол байгуулах шийдвэр гарсан бөгөөд энэхүү авто зогсоолын бэлэг дурсгалын дэлгүүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хийж бүтээсэн бүтээгдэхүүнийг борлуулах лангуу гаргахаар бэлтгэж байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Монгол Улсын Ерөнхий сайдын баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн хурлаас баталсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит хуралдаанаар Хүртээмжийн тухай хуулийг боловсруулж энэ онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг тус яаманд үүрэг болгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 51 дүгээр тушаалаар дээрх хуулийн төсөл боловсруулах салбар дундын ажлын хэсгийг байгуулав. Мөн ажлын даалгаврыг боловсруулж 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдөр батлуулсан бөгөөд “Хүртээмжийн тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах” (БХБЯ-2018ЗҮ/ХТХ-01) ажилд зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж

байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хөтөлбөр үйл ажиллагааны хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартын дагуу бий болгох ажлын хүрээнд жилд 2 удаа зохион байгуулагддаг “Архитекторын мэргэшсэн зэрэг горилогчдод зориулсан сургалт”-ын хөтөлбөрт дээрх чиглэлээр 2-4 цагийн хичээл тусгуулан зураг төсөл зохиогчдод энэ талын зохих мэдлэг олгож байна.

Сонсголгүй иргэдийн мэдээлэл харилцааг зохицуулах үндэсний төвтэй хамтран тус яамны вэб сайт дахь зарим нэг мэдээллийг дохиожуулахаар ажиллаж байна.

- Барилгын салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрт хот төлөвлөлт, барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бий болгох асуудлыг тусгаад байна. 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн холбогдох их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр, агуулгад хүртээмж болон түгээмэл загварын талаарх мэдлэг, ойлголтыг олгох талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд санал хүргүүлээд байна.

Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд шинээр баригдах орон сууцны хотхон, хорооллын барилга байгууламжийн орц, гарцанд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан налуу зам төлөвлөх, цахилгаан шатанд брайль үсгэн тэмдэглэгээтэй товчлуур хийх, гадна авто машины зогсоолын 3 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоол төлөвлөх, хотхон, хорооллын доторх явган замыг хараагүй хүмүүст зориулсан товгор гадаргуутай хавтангаар хийх, барилга байгууламжийн 1 дүгээр давхрын коридорын хананд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бариул зэргийг төлөвлөх түүнийг төлөвлөсөн зургийн дагуу гүйцэтгэх зэрэг ажлыг байнга тогтмол хийж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын яамны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд:

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй, хэрэгцээ шаардлагад нийцсэн барилга байгууламжийн төлөвлөлтөд тавигдах шаардлага” нормативын баримт бичгүүдийг нийтэд сурталчлан таниулах анимейшн хийх ажлын техникийн даалгаврыг боловсруулж 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдөр яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулаад байна. Энэ төслийг 2018 онд багтаан дуусгасан. Нийт төсөвт өртгийн хэмжээ урьдчилсан байдлаар 6.0 сая төгрөг бөгөөд санхүүжилтийг “Барилга байгууламжийн нормативын сан”-гаас гаргасан. “Барилга.МН” сэтгүүл дээр 2018 оны 3 дугаар сараас эхлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн хүртээмжийн асуудлаар булан ажиллуулж эхэлсэн. Одоо “Барилгын мэдээлэл” сэтгүүлд булан ажиллуулах ажлыг эхлүүлнэ.

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо төрийн бус байгууллагаас 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан “Хүний эрх, хөгжил, хамтын

ажиллагаа” сэдэвт семинарт оролцогсдод, 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлд барилга, хот байгуулалтын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр зохион байгуулж байгаа талаар мэдээлэл хийсэн.

Барилга, хот байгуулалтын яам өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа байрныхаа ариун цэврийн өрөөнүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тоноглолыг байрлуулсан зориулалтын өрөөтэй болгож засварласан.

Барилга, хот байгуулалтын яам, Төрийн орон сууцны корпораци, Барилгын хөгжлийн төв зэрэг төрийн байгууллагууд гадна авто зогсоолын талбайдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн авто машин зогсох зогсоолын талбайг тусгайлан тэмдэглэгээтэй болгосон.

Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм” батлагдсантай холбогдуулан барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулсан чадавхжуулах сургалтыг нийслэл, аймгуудад зохион байгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлээр Архангай, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Завхан, Ховд зэрэг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрууд идэвх чармайлттай ажиллаж байна. Мөн нийслэл, дүүргийн Газрын алба сайн ажиллаж байгаа болно.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 442 /Орон сууц, оффис, үйлчилгээний, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, соёлийн төв гэх мэт/ ажлын зураг төсөлд барилга архитектурын 46 орон тооны бус экспертүүдээр дамжуулан магадлал хийх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий орон тооны бус дэд зөвлөл”-ийг Батлан хамгаалахын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлан 2018 онд нийт 13 ажил төлөвлөгдсөнөөс 100 хувь биелсэн. Үүнд:

Нийгмийн хариуцлагын хүрээнд Нийслэлийн 116, 25, 29 дүгээр тусгай дунд сургуулиудтай жил бүр хамтран ажиллаж байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэд тус музейг үзэхэд ашигладаг брайль үсгэн болон дохионы хэлний тайлбарт 5 ширхэг номоор тус тус баяжуулсан.

2. Музейн захирлын 2018 оны А/24 дүгээр тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зорилгоор үнэ төлбөргүй үзүүлэх шийдвэр гарган 2018 оны 03 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулсан ба 190 орчим хүүхэд хамрагдсан.

3. Музейн нээлттэй өдрүүд болон “Олон улсын музейн өдөр”-г тохиолдуулан Нийслэлийн 116, 29, 25 дугаар тусгай сургуулиудын сурагчдад болон “СОС” хүүхдийн хотхоны 60 хүүхдэд “Атар өргөө” ХК-тай хамтран музейн тайлбарт аяллыг зохион байгуулсан;

4. Нийслэлийн 116 дугаар сургуулийн 5 дугаар ангийн сурагчдын дунд буу зэвсэг, хүрч мэдэрч болох үзмэрүүдийг баримал болон керамикаар хийлгэх дадлагын хичээлийг хөгжлийн бэрхшээлтэй 25 хүүхдийн дунд 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан.


5. Нийслэлийн 25, 29 дүгээр тусгай сургуулийн харааны бэрхшээлтэй ахлах ангийн сурагчдын “Монгол түүхийн хичээл”-ийг музейн үзмэрт түшиглэн тус тус зохион байгуулсан. Тайлангийн хугацаанд 2 удаа давхардсан тоогоор 70 гаруй хүүхдэд үйлчилсэн.

- Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн 2017-2018 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 65 хүүхэд суралцаж байгаагаас 20 оюутан боловсролын сангийн зээлээр сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамруулсан

- Нийслэлийн хэмжээнд 169 хөгжлийн бэрхшээлтэй иргэний эцэг, эхээс гаргасан хүсэлтийн дагуу иргэдийг холбогдох хуулийн заалтыг үндэслэн цэргийн албанаас түр болон бүр мөсөн чөлөөллөө.


-2018 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэ төлбөргүй урлаг соёлын үйлчилгээнд хамруулах, хандивын тоглолтыг зохион байгуулах зэрэг хүмүүнлэгийн ажлуудыг зохион байгууллаа.

“Монгол Улсын Барилгын норм ба дүрэм”-ийг үндэслэн Батлан хамгаалах яамны баруун жигүүрийн гадна хаалганы үүдний хэсэг, “Монгол цэргийн музей”-н гол хаалганы баруун талд тэргэнцэртэй иргэдийн зорчих хэсгийг стандартын дагуу шинээр тохижуулан, холбогдох тэмдэглэгээг тус тус хийсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зориулалтын ариун цэврийн өрөөг норм стандартын дагуу төхөөрөмжлөн, засварлаж тохижуулсан.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Цэргийн Соёлын төв өргөөний гадна талбайн гэрэлтүүлгийг бүрэн засварлаж, ордны өмнөх талбайд тэргэнцэртэй иргэдийн авто тээврийн хэрэгслийн зогсоол гаргасан.

Концертын их танхимын 4 дүгээр эгнээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үзвэрийн суудал болгон таних тэмдэг хийж байршуулсан.



Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлын талаар хууль тогтоомж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг дэмжих, нийгмийн хариуцлагын хүрээнд хүртээмжтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, харьяа байгууллагуудыг бодлогоор хангах;
- Батлан хамгаалах салбарын хэмжээнд ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, салбарын хэмжээнд мэдээллийн сантай болох;
- Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бусад яамдуудтай

бодлогын талаар хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нээлттэй аюулгүй орчин бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэх;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдүүдэд сурч боловсрох, спорт, соёл урлаг болон тэднийг хөгжүүлэх орчныг бүрдүүлэх талаар бодлогын хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/013 дугаар тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл байгуулагдсан. Тус дэд зөвлөлд “Бүх нийтийн боловсролын төлөө”, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Дауны холбоо, Энэрлийн түүчээ, Аутизмын холбоо, “Түгээмэл хөгжил” төв, “Сонсголгүй боловсрол” зэрэг 7 төрийн бус байгууллагын төлөөлөл ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан бөгөөд нийт 67 ажил хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны хүсэлтийн дагуу тус холбоо үүсгэн байгуулагдсаны 40 жилийн ойн хүрээнд зохион байгуулах Хараагүй иргэдийн үндэсний урлагын их наадмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/640 дүгээр тушаалаар тус наадмын шагнал, урамшуулалд зарцуулах 7.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

Ерөнхий сайдын дэргэдэх Үндэсний зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй 2-оос доошгүй өрхийн амьжиргааг дээшлүүлэх, орлогын тогтмол эх үүсвэртэй болгох компанит ажлыг яам болон харьяа байгууллагуудын хүрээнд өрнүүллээ. Аяны үр дүнд:

- Хөдөлмөрийн чадвараа 65% алдсан иргэн Р.Болджаргалын ам бүл 6, гэр бүлд таван ханатай, өвлийн дулаалгатай, иж бүрэн тавилгатай шинэ гэрийг худалдан авч өгөв. Мөн Шинэ анагаах ухааны их сургуульд иргэн Р.Болджаргалыг барилгын манаачаар ажилд авч, өөрийн гэсэн хашаагүй тус өрхийг сургуулийн барилгын хашаандаа буулган, тогтмол орлоготой болгоод байна.
- Хөдөлмөрийн чадвараа 100% алдсан, харааны бэрхшээлтэй иргэн Б.Энхбаатарт өөрийн хүсэлтийн дагуу нимгэн төмөр эдлэл хийх төхөөрөмж худалдан авах 2.000.000 /2 сая/ төгрөгийг бэлнээр өгч, ам бүл 5 тус өрхийн бичил бизнес хийхэд дэмжлэг үзүүллээ.

Мөн тус өрхийн 2 том хүүхдийг өөрсдийн хүсэлтээр Хөдөө, аж ахуйн их сургууль болон олон улсын Улаанбаатар их сургуульд бүрэн тэтгэлгээр суралцуулахаар болов. Тус яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын нэг болох Хараагүй болон хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад

зориулсан "Оюутны хөгжлийн төв"-ийг Монгол Улсын Боловсролын их сургуулийн Оюутны V байранд байгууллаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоог хангах зорилгоор зохион байгуулдаг "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал" сэдэвт сургалтад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны нийт албан хаагчид болон харьяа 5 байгууллагын нийт 300 гаруй албан хаагчид хамрагдаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах, нийгэмд оролцох идэвхийг нэмэгдүүлэх, тэднийг нийгмээс тусгаарлаж ялгаварлан гадуурхагдахаас хамгаалах талаар санал солилцлоо.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг их, дээд сургуульд элсүүлэх бодлогын хүрээнд өмчийн хэлбэр харгалзахгүй дээд боловсролын сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг суралцах боломж, эрхийг бүрэн хангах, тусалцаа, дэмжлэг үзүүлэх, тэднийг хөгжүүлэх, ажилд зуучлах, албан хаагч ажиллуулах, дээд боловсролын сургалтын байгууллага нь 300-аас дээш оюутантай тохиолдолд орон тооны, 300-аас доош оюутантай тохиолдолд хавсран гүйцэтгүүлэх шийдвэр /БСШУС-ын сайдын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/261 тоот тушаал/ гаргалаа.

- Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа хийсэн.

Уг судалгаанд харьяа 95 байгууллагын 12176 ажилтан, албан хаагч хамрагдсан бөгөөд хуулийн дагуу 487 (боловсролын салбар-260, соёлын салбар-20, шинжлэх ухааны салбар-5, биеийн тамир, спортын салбар-2) хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах ёстойгоос 287 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан.

- Насан туршийн боловсролын үндэсний төвөөс хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх сургалт зохион байгуулах багш бэлтгэх сургалтыг тус оны 5, 11 дүгээр сард "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадавх бэхжүүлэх нь" сэдвийн хүрээнд тус тус 2 үе шаттай зохион байгуулж, нийт 66 багш, эцэг эх, асран хамгаалагчийг хамруулав. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Насан туршийн боловсролын төвийн багш нар 2017 оноос эхлэн хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 8 хүүхдийг гэрээр сургалтад хамруулав.

Мөн Налайх дүүргийн Насан туршийн боловсролын төвд хөгжлийн бэрхшээлтэй 24 хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна. Үүнээс 16 хүүхдэд гэрээр боловсролын үйлчилгээ үзүүлж байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зориулан соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёл, урлагийн байгууллагаар тав

тухтай үйлчлүүлэхэд шаардагдах эхний шатны ажлуудыг эхлүүлсэн.

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад гаргасан өргөдлийг үндэслэн Чингэлтэй дүүргийн ахмад настан, харааны бэрхшээлтэй иргэн н.Мандах-д 2018 оны 4 дүгээр сард ятга хөгжим олгосон.

2. Хүүхэлдэйн театр 2018 оны 3 дугаар сард хөгжлийн бэрхшээлтэй, тархины саажилт, цусны өвчтэй 150 хүүхдэд “Бүлтээхэй дэлдээхэй хоёр” жүжгийг үзүүллээ.

3. Улсын Филармони Монголын хараагүйчүүдийн холбоотой хамтран санамж бичиг байгуулж, “Бид нэг гэр бүл” зорилтот “Торгоны хээ”, “Гэр бүлийн баяр” төслүүд болон Цусны төвийн хүүхдүүдэд “Хүүхдийн баярын тоглолт”-ыг тус тус зохион байгууллаа.

4. Улсын драмын эрдмийн театр бүх шинээр тоглогдож буй уран бүтээлийн тасалбарыг 50-70 хувийн хөнгөлөлттэйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд борлуулж байна.

5. Үндэсний музей Тайвань улсын буцалтгүй тусламжаар үзэгчдэд зориулсан урсдаг шатыг угсрах ажлыг эхлээд байна. /9 дүгээр сард гүйцэтгэл дуусна./

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөөг тохижуулав.

6. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/295 тушаалыг үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй залуучуудын санаачилсан “Бид давтагдашгүй” загварын урлагийн тоглолтыг 5.0 сая төгрөгөөр дэмжиж хамтран зохион байгуулсан.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл болон бусад арга хэмжээний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд тус яам нь хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг ажлын байраар хангаж, энэ онд нэг ажилтанг гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт дипломат албан тушаалд томилон ажиллуулж байна.

Тус яам нь шинээр барьсан байрандаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажилтныг нэвтрэхэд зориулж зориулалтын гарцыг хийсэн бөгөөд гадаа зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж тэмдэг тэмдэглэгээ тавьсан.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор тухай бүр хуралдаж, зам, тээврийн хөгжлийн орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах ажлыг зохион байгуулж ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчид санаачлан Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр сургууль, харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн болон сонсгол, харааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай

цэцэрлэгийн дэд бүтцийг жишиг байдлаар тохижуулахад олон нийтийг уриалж, мөнгөн хуримтлал үүсгэхээс гадна тодорхой хугацаанд өөрсдийн чадах хэмжээнд тохижилтын ажилд оролцож, зам талбайг нь янзалж, материаллаг дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Санаачлагыг уриалан гаргасан Зам, тээврийн хөгжлийн яамны алба хаагчид 1 өдрийн цалингаа хандивлаж нийт 19 сая гаруй төгрөгийг энэхүү сайн үйлсийн ажилд зориулаад байна. Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Тусгай элч, Дэмжигч байгууллагуудад хандаж, 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хэвлэлийн бага хурал хийж, олон нийтийг уриалан ажилласан.



Зам, тээврийн хөгжлийн яам нь 2018 онд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэрлэсэн нийт 1.827.000 төгрөгийн дугтуйг худалдан авсан байна. Мөн “Нийтлэг үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх групп”-ээс 2018 онд архивын бичиг хэргийн бор цаас худалдан авч нийт 1.960.000 төгрөгийн орлого оруулж хамтран ажиллаж байна.



Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн

М.Баясгалангийн санаачлагыг дэмжиж Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн, урласан бүтээгдэхүүнийг "Чингис хаан" олон улсын нисэх буудлын олон улсын явагчдын танхимд борлуулалт хийх дэлгүүрийн зай талбайг гаргаж нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар анхаарч ажилласан.



Мөн "Чингис хаан" олон улсын нисэх буудлын олон улсын явагчдын танхимд "Харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын төв" болон "Асрал" төв төрийн бус байгууллагын хандивын хайрцагийг байрлуулсан.



Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн зорчигч үйлчилгээний төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг хүргэх зорилгоор тасалбар захиалгын системд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан суудал" гэсэн сонголтыг нэмж

үйлчилгээнд ашиглаж байна.

Amadeus системд шилжсэнтэй холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй зорчигчийн суудал захиалгад сонсголгүй зорчигч DEAF, хараагүй зорчигч бол BLIND ... гэсэн AIRIMP кодыг оруулах зорчигч дагалдах хүнгүй аялах тохиолдолд явах болон буух нисэх онгоцны буудалд үдэх, угтан авах хүний нэр, утас, хаягийг оруулсан байхаар зохицуулсан буюу кодыг оруулахад дотоодын болон гадны буудал station дээр системээр зэрэг харагдаж, тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэн хаана ч нэгэн ижил үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж өгсөн.

Зам, тээврийн хөгжлийн яамны 105 тоот өрөөг хөгжлийн бэрхшээлийн иргэдийг хүлээн авч уулзах уулзалтын өрөө болгон тохижуулж, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлээд байна.

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Салбарын хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар зохицуулалт оруулах. Тухайлбал: Иргэний нисэхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар зохицуулалт оруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;
- Зам талбай, нийтийн тээврийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, шаардлагатай стандарт, удирдамжийн баримт бичгийг шинэчлэн боловсруулах;
- Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангах ажлыг эрчимжүүлэх.

САНГИЙН ЯАМ

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу Сангийн яаманд 1, гаалийн байгууллагын хэмжээнд 3, татварын байгууллагад 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна.

Сангийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Хуулийн төсөл боловсруулах явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хангалт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл болох Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө үндэсний зөвлөл, Монголын хараагүйчүүдийн нийгэмлэг, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо зэрэг байгууллагын төлөөлөлтэй уулзаж, саналыг нь тусгах ажлыг зохион байгуулж байна.

Тус яамны боловсруулсан хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар дэмжиж, УИХ-д өргөн барьсан бөгөөд хуулийн төслийг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр УИХ-аар хэлэлцэж, хуулийн төслийг цаашид хэлэлцэх нь зүйтэй гэж дэмжсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн тендерт оролцогчдод давуу эрх олгох зохицуулалт болох 10 дугаар зүйлийн 10.1.7-д “ажиллах хүчний 50 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж” гэснийг “ажиллах хүчний 30 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн эзэлдэг, 25 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж” гэсэн өөрчлөлтийг оруулсан.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлиг, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2017 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий орон тооны бус дэд зөвлөлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/122 дугаар тушаалаар байгуулсан.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2018-2019 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллах тухай ажлын төлөвлөгөө боловсруулж 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдөр тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/3082 тоот албан бичгээр салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах чиглэл өгсөн.

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газрын нэтгэсэн дүн мэдээгээр 2016 онд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 101 аж ахуйн нэгжийн нийт 22347 ажиллагсдын 1% нь буюу **238**, 2017 онд 162 аж ахуйн нэгжийн нийт 18599 ажиллагсдын 2% буюу **296** хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. - Бичил уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг таслан зогсоох, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор салбарын сайдын “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 06 тоот албан даалгавар гарсан ба орон нутгийн Засаг дарга, холбогдох газар нэгж, агентлаг болон салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэв. Албан даалгаварт хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих тэдгээр иргэдийн эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх /үүнд: орох, гарах гарцын шийдэл, мэдээллийн хүртээмж, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх/ талаар тус тус тусгагдсан.

Насанд хүрээгүй хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг таслан зогсоох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үүднээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын аймгийн Засаг дарга нартай 2019 онд байгуулах хамтран ажиллах гэрээ болон Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 2019-2020 оны хамтын хэлэлцээрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай асуудлыг тусгахаар саналыг боловсруулж хөдөлмөрийн нийгмийн зөвшлийн хуралдааныг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2018 оны 12 дугаар сард багтаан Өмнөговь аймгийн Эрдэнэс-Тавантолгойн нүүрсний орд газрын ашиглалтын үйл ажиллагаа, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай салбарын сайдаас гаргасан чиглэл болон албан даалгаврын хэрэгжилттэй танилцахаар бэлтгэж байна.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл, түүний ажиллах журмыг баталсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тэднийг нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн оролцох, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн орчин бүрдүүлэх чиглэлээр тус яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлөөс 2018 онд 11 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан. Тухайлбал,

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхийг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний 12 агентлаг, байгууллага 2018 онд 76 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж ажилласан бөгөөд хүйсийн байдлаар авч үзвэл 47.36% нь эрэгтэй, 52.64% нь эмэгтэй байна.

Эрх зүйн боловсролыг дэмжих чиглэлээр:

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Иргэдийн эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр, гарын авлагыг зорилтот бүлгийн хэрэгцээнд тулгуурлан боловсруулах, сургалт зохион байгуулах” ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэн “Бизнес инкубатор” төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэлээ. Энэ ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй

иргэдээс тухайлсан судалгаа авч, хэлэлцүүлэг зохион байгуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулах ажил хийгдсэн.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд хэвлэн гаргах “Өрхийн эрх зүйн хөтөч” /гарын авлага/ номонд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэх харилцааны онцлог, нийгмийн халамж, тусламж, үйлчилгээ” сэдвээр тусгайлан бүлэг эрхлэн гаргахаар төлөвлөсөн бөгөөд 2019 оны I улиралд хэвлүүлэхээр эхийг бэлтгэж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхэд хамаарах эрх зүйн баримт бичиг эмхэтгэн гаргах ажлыг “Монголын хараагүйчүүдийн төв” төрийн бус байгууллагатай хамтран гэрээ байгуулж, тус бүр нь 153.000 төгрөгийн үнэ бүхий нийт 30 ширхэг номыг брайль үсгээр хэвлүүллээ.

Хууль зүйн туслалцааны төвөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хууль зүйн мэдлэг олгох, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн 160 иргэнийг хамруулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагааг сонсголын бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тайлбарлах хэлмэрч, хөтчийг бэлтгэх сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран зохион байгуулж, 11 албан хаагчийг дохионы хэлмэрчээр бэлтгэсэн.

Цагдаагийн байгууллага, “Монголын сонсголгүй иргэдийн холбоо” төрийн бус байгууллагатай хамтран сонсголын болон хэл, ярианы бэрхшээлтэй 212 жолоочид Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмийн талаар 2 цагийн сургалт зохион байгуулсан. Мөн “Цаг үргэлж” авто сургуульд бэлтгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй 28 сонсогчоос шалгалт авч, эдгээр иргэдийн материалыг жолоочийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулж, тээврийн хэрэгслийн жолоодох үнэмлэхийг хэвлэж олгосон.

Мөн дүүрэг дэх 7 цагдаагийн хэлтсийн жижүүрийн албаны цонхоор тэргэнцэртэй иргэд үйлчлүүлэх боломжтой байдлаар нам дор байрлуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сануулж, дохио өгөх зорилгоор хонх байрлуулсан ба дүүрэг дэх 17 цагдаагийн хэлтсийн жижүүрийн албаны иргэдэд үйлчлэх цонхны хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дугаар, цагийн хуваарь харгалзахгүй үйлчлүүлнэ” гэсэн бичиглэл, таних тэмдэг бүхий зурагт хуудас байрлуулан гадна автомашины зогсоол, унадаг дугуйн зогсоол ажиллуулж байна.

Хил хамгаалах ерөнхий газар нь хил хамгаалах байгууллагаас төрийн үйлчилгээ авах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрхийг хангах зорилгоор Хил хамгаалах ерөнхий газар, хилийн анги, салбар, боомтуудад Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2011 оны 256 дугаар тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл зохиох дүрэм”-ийн шаардлагад нийцсэн

тэмдэглэгээ, явган хүний зам, халтиргаагүй шат ба налуу зам, бариул, хаалга, ариун цэврийн өрөө зэргийг нийт 2.3 сая төгрөгөөр төхөөрөмжилж, боомтуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусгай кабинаар дараалал харгалзахгүй үйлчилж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Иргэний бүртгэлийн ерөнхий газар, Гадаад иргэний харьяатын газар, тус яамны эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараалал харгалзахгүй үйлчлэх боломжийг бүрдүүллээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлаг, байгууллагуудын нийтийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй эсэхэд дүгнэлт гаргаж, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг зохион байгуулж, нийтийн зориулалттай барилга байгууламжуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэн орох, гарах, үйлчлүүлэх зориулалтын зам, тусгай тэмдэглэгээ, зорчих хэсэг, налуу шат зэргийг хийж гүйцэтгэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх бүхий л боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.

- Цагдаагийн ерөнхий газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих “Цаг үргэлж” хоршоотой хамтран Бүртгэл хяналтын төвийн байрны орох хэсэгт налуу шат, төв хаалганы харалдаа тусгай гарц, авто зогсоол шинээр хийж, тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан. Мөн Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистикийн хэлтсийн лавлагааны байр, Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газрын төв байрууд, Төмөр зам дахь цагдаагийн газар, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 2, Баянгол дүүрэг дэх цагдаагийн 1, 2, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1, 2, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 1, 2, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 1, 2, Багануур, Налайх, Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Төв, Увс, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь цагдаагийн газрууд MNS 6055:2009 үндэсний стандартад нийцүүлэн зориулалтын бариул бүхий налуу замтай болсон.

- Нийслэлийн цагдаагийн газрын төв байр, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3 дугаар хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн байранд хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө бий болгосон.

- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн хөгжлийн бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй иргэдэд зориулж хүрээлэнгийн төв байрны орох хэсэгт шинээр зам хийсэн.

- Хууль сахиулахын их сургуулийн хичээлийн байранд хөгжлийн бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй иргэн зорчих хэсгийг хийсэн.

- “Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах Монголын нийгэмлэг” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан 24.620.000 /хорин дөрвөн сая зургаан зуун хорин мянга/ төгрөгийн төсөв бүхий чанарын шаардлага хангасан тэмдэг тэмдэглэгээ, гарц, гэрлэн дохио байгуулах ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

- Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Ханнс-Зайделийн сантай хамтран иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр бэлтгэсэн 14 видео санамжийг сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан дохионы хэлээр орчуулж, яам, түүний харьяа 12 агентлаг, байгууллагын цахим хуудас болон үйлчилгээний зааланд байрлах дэлгэцэнд байршуулсан.

- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийж буй хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, сурталчилгааны www.e-khutuch.mn портал цахим хуудсанд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх” сэдвээр контент мэдээлэл бэлтгэн оруулсан.

- Цагдаагийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй иргэдээс яаралтай дуудлагын 104 тусгай дугаараар богино мессеж авах үйлчилгээг нэвтрүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхсан заалт буй эсэхэд үнэлгээ хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгааны ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар бусад орны хууль тогтоомжтой харьцуулан судлах судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2018 онд хийж гүйцэтгэсэн.

Судалгааны дүнд гарсан саналыг тус яамнаас Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд хүргүүлсэн. 2019 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар дараах саналыг гаргасан болно. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, Монгол Улсын Үндсэн хуулиар заасан эрхийг өргөжүүлэн хуульчилсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага нь тодорхойгүй, өөрөөр хэлбэл хориглосон, үүрэгжүүлсэн зохицуулалтад Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцох;
- Хууль тогтоомжид “тахир дутуу” гэж зохицуулсан зохицуулалтыг хөгжлийн бэрхшээлтэй гэдэг утгаар өөрчлөх;
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйл, Эрүүл ахуйн тухай хуулийн 2 дугаар зүйл, 5 дугаар зүйл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйл гэх мэт хууль тогтоомжид заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн нэрийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль гэж өөрчлөх;
- Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн “хөгжлийн бэрхшээлтэй суралцагч гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 3.1 дэх заалт” гэж эшилсэн заалт зөрүүтэй байх тул өөрчлөн найруулах;

- Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.8-д” гэж эшилсэн заалт зөрүүтэй байх тул өөрчлөн найруулах;
- Автотээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлд “... нийтийн тээврийн 10-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн тээвэрлэхэд зориулсан байх” тухай заасан нь тэдний зорчих эрх хангагддаггүй, ялгаварлан гадуурхалтад өртөж байх тул “нийтийн тээврийн хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй хүн тээвэрлэхэд зориулагдсан байх” гэж өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, дэд зөвлөлийн хурлыг жилд 2 удаа тогтмол хийж хэвших;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах;
- Нийтийн зориулалттай барилга байгууламжийг холбогдох стандартын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох ажлыг салбарын хэмжээнд үргэлжүүлэн зохион байгуулах;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын цахим хуудсуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан 4*6 хэмжээтэй хүлэмжийг олгоод байна.



Хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүнсний ногооны өргөст хэмх, хүлэмжийн лооль, амтат чинжүү, дунд оройн байцааны үр зэрэг 4 төрлийн үр, үрийн суулгац олгож, дэмжлэг үзүүлсэн.



Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд зээл авах боломж нөхцөлийг нэмэгдүүлэх, хангах зорилгоор 2018 оны 1 дүгээр сард хамтран ажиллах гэрээ байгуулан 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 23,0 сая төгрөгийн зээлийн батлан даалт гаргасан байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Бизнес инкубаторын холбоогоор дамжуулан хэрэгжүүлж буй бичил зээлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зээл олгож байна. Энэ хүрээнд 2018 оны хагас жилийн байдлаар 6 зээлдэгчдэд 70,3 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр нэмэлт хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн баруун бүс дахь Драгон салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн борлуулах борлуулалтын цэгийг нээсэн. Тус борлуулалтын цэгээр дамжуулан 32 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бараа бүтээгдэхүүн худалдаалагдаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд”, “Монголд үйлдвэрлэв” 2 удаагийн үзэсгэлэн худалдаанд болон хурал,



сургалтад 15 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж ажилласан.

Тус яамны салбар зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан 2 хурлын үйл ажиллагааны бичиг хэргийн болон бусад зардалд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн даавуун уутыг худалдан авсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан хаагчдад “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт”-ыг зохион байгуулсан.

ХХААХҮС-т хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоод болон иргэдэд хүргэх зорилгоор Facebook хуудас нээн холбогдох мэдээллийн хэрэгслээр төсөл хөтөлбөрийн мэдээллийг хүргэж ажиллаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл”-ийг Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/229 дүгээр тушаалаар байгуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

“Хөгжлийн бээршээлтэй хүүхдийн хөгжлийн дэмжлэг үзүүлэх загвар, маяг”-ыг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/304, А/699, А/460 дугаар тушаалаар батлууллаа.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Баянхонгор аймаг 2018 оныг сонсголын бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих жил болгон зарлаж, Сэтгэлийн сонсголон, Яаралтай, Бид өөрчлөгчид зэрэг бичил төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

- a. Яаралтай төслийг хэрэгжүүлснээр Онцгой байдлын 101, Цагдаагийн 102, Эмнэлгийн 103 тусгай дугаарын утсанд сонсгол хэл ярианы бэрхшээлтэй 1900 иргэд, хүүхэд бусдын дэмжлэг туслалцаа шаардлагагүйгээр, интернетгүй орчноос ч яаралтай дуудлагыг шуурхай удирдлагын төвд өгөх нөхцөлийг бүрдүүлсэн. Дуудлага хүлээн авагч албан хаагчдыг дохионы хэлний сургалтад хамруулснаар үйлчилгээг бүрэн үзүүлэх чадвартай болсон.
- b. Бид өөрчлөгчид төслийн хүрээнд төрөлхийн сонсгол хэл ярианы бэрхшээлтэй 3 гэр бүлийг сонгон авч бага насны хүүхдүүдийг нь цэцэрлэг, сургуульд хамруулан, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад үндсэн ажилтнаар оруулсан байна.
- c. Улсын хэмжээнд анхдагч болон санаачилсан “Сэтгэлийн сонсголон” хөтөлбөрийг 2018 оны 4 дүгээр сараас эхлэн УНТЭ-тэй хамтран 2 үе шаттай хэрэгжүүлж, 45 сонсголын бэрхшээлтэй иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 25 иргэнийг хэнгэрэг нөхөх мэс засал эмчилгээнд оруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллага бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр налуу зам, дуугүй хөтөч, ханын бариул, ариун цэврийн өрөөний дотоод орчин, суултуур зэргийг хийж 5.000.000 гаруй төгрөгийг зарцуулсан байна.

Булган аймаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, тэгш байдлыг хангах ажлын хүрээнд “Хариу нэхээгүй тус” сарын аяныг 10 дахь жилдээ зохион байгуулж хэвшээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх анхдагч мэдээллийн сан байгуулах улсын үзлэгийг зохион байгуулахад хамтран ажиллаж, эрүүл мэндийн салбарын мэдээний санг бүрэн шинэчилсэн.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын ВИЖН 2020 стратегийн хүрээнд Эрүүл мэндийн яам, Монголын нүдний эмч нарын нийгэмлэг, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хамтран сул хараатай иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах, чанартай мэргэжлийн түвшинд ард иргэдэд тусламж үзүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллага болох Америкийн нэгдсэн улсын хараагүйчүүдийн Перкинс олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун эргийн бүсийн хөгжлийн бэрхшээл ба сэргээн засах асуудал хариуцсан техникийн багийн ахлагч Даррилл Барретт Монгол Улсад 2018 оны 5 дугаар сард албан айлчлал хийж, нөхцөл байдалтай танилцсан. Цаашид Монгол Улсын сэргээн засах тусламж, үйлчилгээний өнөөгийн байдлын үнэлгээ хийх, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах чиглэлээр хамтран ажиллана.

Мөн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, олон улсын үйл ажиллагааны ангиллыг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Монгол Улсын урт хугацааны тусламж, үйлчилгээний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад хамтран ажиллана.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 291 дүгээр тогтоолоор “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ыг шинэчлэн баталсан бөгөөд тус дүрмийн 5.3 дахь хэсэгт төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг тусгаж, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 217 дугаар тогтоолоор төвийн бүсийн хэмжээнд ахуйн хэрэглэгчдэд цахилгааны нэгж өртөг (145.84 төг/кВт.ц)-өөс 44.3-58.8 хувиар бага тарифаар жилдээ хөнгөлөлт үзүүлж, уг тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 217 дугаар тогтоолоор төвийн бүсийн хэмжээнд 2100 орчим ахуйн хэрэглэгчдэд цахилгааны нэгж өртөг (145.84 төг/кВт.ц)-өөс 44.3-58.8 хувиар бага тарифаар жилдээ 2,989.0 мян.кВт.ц буюу 176.4 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй мэргэжлээс шалтгаалах өвчнөөр группэд байдаг иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд “ДЦС-4” ТӨХК-нд 2005 оны 06 дугаар сарын 27-ны өдөр 40 хүний орон тоотой тохижилт үйлчилгээний бригадийг үүсгэн байгуулж одоог хүртэл ажиллуулж байна.

Тус салбарт, Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр /МШӨ/ хөдөлмөрийн чадвараа алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон 222 хүн байна. 2011 оноос мэргэжлээс шалтгаалах өвчнөөр группэд гарсан иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага байгуулагдаж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрчим хүч, геологи, уул уурхайн яам, Үйлдвэрчний эвлэлийн холбоодуудтай ажил хэргийн

олон удаагийн уулзалт хийсний үр дүнд Монголын Эрчим хүч геологи уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо болон Эрчим хүчний яамны хамтын гэрээ хэлэлцээрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар тусгай бүлэг, заалт оруулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалин хангамж нэмэгдэж, компанийн бага тушаалын албан хаагчийн цалингийн хэмжээнд хүртэл хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлж, өвөл зуны хоёр ээлжийн ажлын дүрэмт хувцасаар бүрэн хангаж, ахуй байрных нь нөхцөлийг сайжруулж ажиллалаа.

Жил бүрийн 4 дүгээр сарын 28-нд Хамтын гэрээний дагуу Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр группэд байдаг хөгжлийн бэрхшээлтэй ажилчин, албан хаагчдыг хүлээн авч нөхөн төлбөр, буцалтгүй тусламж олгодог болсноор долоон жилийн хугацаанд нийт 140 920 000₮-ийг зарцууллаа. Мөн жил бүр компанийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэлд байгаа 187 хүнд өвлийн хэрэгцээнд нь зориулж 5 тнн нүүрсийг бэлтгэлийн үнээр нь хөнгөлөлттэй үнэ 220000 төгрөгөөр олгож байна.

“ДЦС-3” ТӨХК-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах үүднээс компанийн эмнэлгийн эмчийн хяналтан доор эрүүл мэндэд нь тохируулж алжаалах өрөө буюу хаш чулуун массаж, физик эмчилгээ, чийрэгжүүлэх танхим зэргээр тогтмол үйлчлэн ажиллаж байна. Мөн ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг хангах зорилгоор теннис, бильярд, бялдаржуулах болон цэнгээнт бүжгийн танхим ажиллуулаад байна.

Одоогоор “ДЦС-3” ТӨХК нь Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон 40 хүнийг авч ажиллуулж байгаагаас, ИТА 6 байгаа бөгөөд жирийн ажилчдын адил цалин хангамжаар хангагдаж жил бүр 10 хоног хуваарийн дагуу рашаан сувилалд амрааж эрүүлжүүлэх арга хэмжээг тогтмол авч, мөн компанийн зоогийн газарт эрүүл ахуйн кабинет ажиллуулж тухайн өвчтөний биеийн байдалд тохирсон эмчилгээний хоол хүнсээр үйлчлэх ажлыг санаачлан хэрэгжүүлж хэвшүүлээ.

Нийгмийн хариуцлагын хүрээнд тус компани нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн дагуу нийт ажилчинд ногдох хөгжлийн бэрхшээлтэй тахир дутуу иргэдийн үлдсэн тоонд сард 2.280.000₮, жилд 27.360.000₮-ийг Хөдөлмөр эрхлэлтийн санд шилжүүлдэг. Мөн олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвараа алдсан ажилчдын хөдөлмөрийг үнэлж, “Эрчим хүчний тэргүүний ажилтан” цол тэмдгээр 52 хүнийг шагнаж урамшууллаа.

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Салбарын хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар зохицуулалт оруулах;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зөв, бодит мэдээллээр хангах, санал, өргөдөл гомдлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн

болон төрийн бус байгууллагаар салбарын үйлдвэр компанийн ажилтнуудад жил бүр сургалт зохион байгуулах, санал гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэж буй ажилд хяналт тавих;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагаар эрчим хүчний салбарын ажиллагсад сургалт хийлгэж хандлагыг өөрчлөх;

Мөн эрчим хүчний салбарын түгээх байрнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний үйлчлүүлэх ээлтэй, хүртээмжтэй орчинг бүрдүүлэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангах ажлыг эрчимжүүлэх.

ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас санаачлан Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг сайжруулах, дэмжих зорилгоор “Монгол бичвэрийг авианд хөрвүүлэх програм хангамж боловсруулах” төслийг хэрэгжүүлсэн. Тус төслийн дэлгэц уншигч програм хангамж нь үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Бичгийн текстийг яриа болгох систем буюу ярианы синтез
2. Тухайн синтезийг дэмждэг дэлгэц уншигч програм хангамж боловсруулсан

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хангах тухай хуулийн 11.2.4-т “Цахим хуудас болон телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлбэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар ав хэрэгжүүлэх”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 11.2.5-т “Төрийн болон нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, бичигч, уншигч, хөтчийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх” гэж тус тус заасан хуулийн хэрэгжилт хангагдана. Уг төслийг холбогдох байгууллагад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Засгийн газрын 2017 оны 116 тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий орон тооны бус дэд зөвлөлийг төрийн захиргааны төв байгууллага болон харилцаа холбоо, мэдээлэл технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд байгуулан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт үүрэг болгосны дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүн болон ажиллах журмыг боловсруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Мэдээлэл харилцаа холбооны салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

АРАВДУГААР БҮЛЭГ: ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. Японы олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй төслүүдийн танилцуулга

1.1 Төслийн нэр: Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)

1. Үндсэн мэдээлэл

Төслийн хугацаа: 2016.5.31- 2020.5.30

Хэрэгжүүлэгч байгууллага: Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Төслийн хамрах хүрээ: Улаанбаатар хот

2. Ерөнхий тойм

Монгол Улс 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон. 2012 онд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтэс байгуулагдсан. 2013 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хууль болон Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон ба 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль батлагдсан.

Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон нийгмийн оролцоотой холбоотой ойлголт хандлагууд идэвхтэй болж ирсэн. Мөн төрийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төрийн бус байгууллагуудтай хамтран нийгмийн нөлөөллийн үйл ажиллагаа явуулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх болон нийгмийн оролцооны талаар олон нийтийн ойлголт, хандлага сайжирч байна.

Нөгөөтэйгүүр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааны түвшин доогуур байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн тусгай тохируулга бүхий ажлын байр хангалтгүйн улмаас хөдөлмөр эрхлэлтэд ахиц дэвшил гарахгүй байна. Нийтийн тээвэр, барилга байгууламжийн саадгүй байдал, цахим тоног төхөөрөмж зэрэг мэдээллийн хүртээмжтэй байдал, халамжийн туслах хэрэгсэл дутагдалтай байгаа. Мөн түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллага, дэмжигч байгууллагуудыг хамруулсан чадавхжуулах сургалт хангалттай явагддаггүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог бодитой болгох үндэс суурь бэхжээгүй байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэх үүднээс Монгол Улсын Засгийн газар Улаанбаатар

хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийг хэрэгжүүлэх саналыг Япон улсын Засгийн газарт тавьснаар тус төсөл хэрэгжих болсон.

3. Төслийн зорилго

Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих тогтолцоог бэхжүүлэх

Үр дүн 1: Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд бүрдүүлэх

Үр дүн 2: Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх

Үр дүн 3: Улаанбаатар хот дахь дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийг сайжруулах нөөцийг бүрдүүлэх

Үр дүн 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны чадавхийг бэхжүүлэх

4. Өнөө хүртэлх томоохон үйл ажиллагаа, үр дүнгээс

- Тус төслийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай” (DET) сургалт явагдаад 2 жил болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургагч багшаар бэлтгэн, DET сургалтыг эдгээр бэлтгэгдсэн багш нар явуулдгаараа онцлогтой. Тус сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өдөр тутам тулгарч байгаа асуудал, шийдвэрлэх гарцыг оролцогчдоор өөрсдөөр нь тодорхойлуулах зорилготой сургалт юм. 2018 оны 4 дүгээр сар хүртэл нийт 32 DET сургалтын сургагч багшийг бэлдэн гаргасан. 2018 оны 12 дугаар сарын сүүл хүртэл төр болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилд нийт 229 удаагийн сургалтыг зохион байгуулж ороцогчдын нийт тоо 7445 хүрсэн байна.
- 2016 оны 8 дугаар сараас эхлэн хүртээмжийн талаарх үнэлгээ хийж, 2017 оны 3 дугаар сард Япон улсаас мэргэжилтэн урин хүртээмжийн тухай семинарыг зохион байгуулсан. Тус семинараар төр, төрийн бус байгууллагын төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэний оролцоотой үнэлгээний арга барилд суралцсан. Мөн түүнчлэн Хөшигтийн хөндийн нисэх буудал, нийслэлийн 9 дүүрэгт дэх дэд бүтцийн хүртээмжийг үнэлэх зэргээр төр засгийн байгууллагатай хамтран бие даан үнэлгээ хийх аргад нийт 65 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургасан. Зөвхөн үнэлгээ хийх нь дэд бүтцийн хүртээмжийг сайжруулахад хангалтгүй гэдэг нь тодорхой болсон. Дэд бүтцийн хүртээмжийн тухай хууль, дүрэм, журам байдаг ч хэрэгжилт хангалтгүй байна. Ялангуяа “Барилгын зөвшөөрөл олгох тогтолцоо” болон “Холбогдох байгууллагууд (Төрийн байгууллага, барилгын компани,

архитектур зэрэг)–ын мэдлэг, ойлголт”-той холбоотой асуудлууд нь үүний нэг томоохон шалтгаан гэж хэлж болно. Тиймээс дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр техникийн хамтын ажиллагааг цаашид улам өргөн хүрээнд явуулах хэрэгтэй байна.

- Төрөөс хөгжлийн бэрхшээлийн салбарт авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээг ард иргэдэд мэдээлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал-Бодлого үйл ажиллагаа” Мэдээллийн лавлах (цагаан ном)-ыг боловсруулан, хэвлэж гаргахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллаж байна. 2018 оны 3 дугаар сард Монгол Улсын анхны мэдээллийн лавлах (цагаан ном)-ыг хэвлэн гаргасан бөгөөд 2019 онд 2 дахь дугаарыг бэлтгэлээ. Мөн хөгжлийн бэрхшээлийн салбарын анхдагч мэдээллийн санг байгуулахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хорооны хамтарсан ажлын хэсэгт зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрийн албан хаагчдыг чадавхжуулах үйл ажиллагааны хүрээнд “Залуу манлайлагч бэлтгэх цуврал сургалт”, “Хөгжлийн бэрхшээлийн тухай цуврал сургалт”-ыг тус тус зохион байгуулж давхцсан тоогоор 650 орчим хүнийг хамруулсан. Түүнчлэн Япон улсад зохион байгуулагдсан “Сэдэвчилсэн сургалт”-д төрийн бус байгууллагын төлөөлөл 6 хүн, төрийн байгууллагын төлөөлөл 2 хүнийг, “Багийн сургалт”-д төрийн бус байгууллагын төлөөлөл 10 хүн, төрийн байгууллагын 16 хүнийг тус тус хамруулаад байна.(Хүснэгт)

Хүснэгт : Япон улс дахь сургалтын сэдэв ба оролцогчид

Сэдэвчилсэн сургалт		
2016 он 9-12 сар	Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх болон сүлжээ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1 хүн
2017 он 1-3 сар	Оюуны болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх бүс нутгийн дэмжлэг ба үйл ажиллагаа	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1 хүн
2017 он 6-7 сар	Бүх хүмүүст ээлтэй орчны хүртээмжийг сайжруулах – Саадгүй орчныг бий болгох тухай	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1 хүн, төрийн байгууллагаас 1 хүн
2017 он 9-11 сар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенцийг хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч залуусын чадавхийг бэхжүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1 хүн
2018 он 2-3 сар	Оюуны болон Хөгжлийн хоцрогдолтой иргэдэд үзүүлэх бүс нутгийн дэмжлэг ба үйл ажиллагаа	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1 хүн
2018 он 8-9 сар	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтийн оролцоотойгоор нийгэмд тэгш хамруулах, ерхийн амьжиргаа	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих төрийн бус байгууллага 1 хүн, Төрийн байгууллагаас 1 хүн
Багийн сургалт		

2017 он 2 сар	Япон улсын хөгжлийн бэрхшээлийн халамжийн тогтолцоо болон бодлого, дэд зөвлөлийн тухай	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих төрийн бус байгууллага 3 хүн, Төрийн байгууллагаас 7 хүн
2017 он 7-8 сар	Хөгжлийн бэрхшээлийн талаарх тоо баримт ба судалгаа	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих төрийн бус байгууллага 2 хүн, Төрийн байгууллагаас 8 хүн
2017 он 12 сар	Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх сургалт	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих төрийн бус байгууллага 5 хүн, Төрийн байгууллагаас 1 хүн



Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай (DET)



Дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн семинар

Төслийн цахим хуудас

Япон хэл дээр : <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

Монгол хэл дээр : <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/015/index.html>

Англи хэл дээр : <https://www.jica.go.jp/project/english/mongolia/015/index.html>

Төслийн Facebook (Япон • Монгол) : <https://www.facebook.com/jicadpub/>

1.2 Төслийн нэр: Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл

1. Үндсэн мэдээлэл

Хугацаа : 2015.08~2019.07(4 жил)

Хэрэгжүүлэгч байгууллага: Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Туршилтын орон нутаг : Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, Хөвсгөл аймаг

Туршилтын сургууль : 25, 55, 63, 70 дугаар тусгай сургууль, Улаанбаатар хотын

16, 26, 28,34, 35, 79, 111, 113 дугаар сургууль, Хөвсгөл аймгийн “Ирээдүй XXI зуун цогцолбор сургууль”, “Титэм сургууль”

2. Үндэслэл

Монгол Улс 2016 оны 2 дугаар сард Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталсан. Тус хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2017 онд Монгол Улсын Засгийн газрын 321 дүгээр тогтоолоор баталлаа. Тус хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай иргэд, олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах, бодлого тогтолцоондоо хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар тусгах, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг Засгийн газрын бодлого чиглэлийг тодорхой тусгасан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 40 орчим хувь нь цэцэрлэг, бага сургуульд хамрагдаж байгаа бөгөөд дунд сургуульд дэвшин суралцаж байгаа нь 14 хувь байна /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр/. Хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой нь илэрсэн ч шаардлагатай хөгжлийн дэмжлэгийг хүлээн авч чадахгүй байх, гэр бүлийн дэмжлэгийн тогтолцоогүй байх, сургууль хүлээн авч суралцуулах тогтолцоогүй байх зэргээс шалтгаалан хүүхэд сургуульд хамрагдаж чадахгүй байдалд хүрнэ. Сургуульд хамрагдсан ч хэрэгцээндээ нийцсэн боловсрол эзэмшиж чадахгүй сургуулиас гарах тохиолдол цөөнгүй байсаар байна.

Ийм нөхцөл байдал дунд тус төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг сайжруулах зорилгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

3. Зорилго, зорилт

Төслийн зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох

Зорилт 1 : Туршилтын аймаг дүүрэг дэх холбогдох байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх үйлчилгээ, хөгжлийн дэмжлэгийг хэрэгжүүлэх чадавх бэхжинэ.

Зорилт 2 : Туршилтын сургуулийн холбогдох байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй /оюуны бэрхшээл/-д чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх чадавх бэхжинэ.

Зорилт 3 : Бичил төслөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн олон төрлийн боловсролын үйлчилгээний хэлбэр, загвар, түүний үр дүн батлагдана.

Зорилт 4 : Зорилт 1-3-ын харилцагчид хоорондын туршлага солилцох болон төр

засгийн байгууллагын бүтэц болон бодлогод тусгагдана.

4. Төслийн гол үйл ажиллагаа, үр дүнгийн танилцуулга

<p>Ерөнхий үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комисс, холбогдох байгууллагуудын чиг үүргийг заасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-ыг боловсруулж байна. • Хөгжлийн дэмжлэг шаардлагатай хүүхдийн бодит байдалд цогцоор нь үнэлгээ хийж, үр дүнтэй хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах чадвартай болгох зорилгоор Кэйс хэлэлцүүлэг (бодит жишээн дээр хэлэлцүүлэг хийх) зохион байгуулж байна. • Багшийн мэргэжил дээшлүүлэх онлайн сургалтын агуулгад зориулж, “Тэгш хамруулан сургах боловсрол” сэдэвчилсэн видео хэрэглэгдэхүүн боловсруулах.
<p>Сургуулийн өмнөх боловсролын дэмжлэг</p>	<ul style="list-style-type: none"> • “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн ашиглалтыг сайжруулна. • 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн иж бүрэн үзлэгийг туршин хэрэгжүүлж, нэвтрүүлнэ. • Хөгжлийн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн иж бүрэн үзлэг хийж, хөгжлийн хоцрогдол, бэрхшээл илэрсэн хүүхдүүд, тэдний асран хамгаалагчдаас хүсэлт гаргасан тохиолдолд тэдэнд зориулан эцэг/эх хүүхдийн хөтөлбөрийг зохион байгуулна. • Хөгжлийн дэмжлэг үзүүлэх хэрэглэгдэхүүн боловсруулах хүрээнд “Шинэчлэгдсэн Портеж эрт боловсролын хөтөлбөр”-ийн Монгол хувилбарыг хэрэгжүүлнэ. • Цэцэрлэгийн багш нарт зориулсан сургалт зохион байгуулна.
<p>Сургуульд элссэний дараах дэмжлэг</p>	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн” боловсруулан ашиглана. • Оюун ухааны хоцрогдолгүй боловч сурлагын хувьд дэмжлэг шаардлагатай хүүхдийн бодит байдлыг ойлгох, багшлах арга зүйгээ сайжруулах зорилгоор “Сурлагын хоцрогдолтой, зан төлвийн асуудалтай хүүхдийн боловсролд дэмжлэг үзүүлэх хэрэглэгдэхүүн-зөв ойлголт, хандлагатай болж багшлах арга зүйгээ сайжруулах” хэрэглэгдэхүүнийг боловсруулан ашиглана. • “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар, боловсруулах аргачлалыг боловсруулна. • Тэгш хамруулан сургах боловсролыг дэмжин ажиллах үүрэг бүхий “Сургуулийн дэмжлэгийн зөвлөл”-ийг байгуулж туршина. • Туршилтын сургуулийн багш нарын багшлах арга зүйг сайжруулах судалгаат хичээл, жишээ хэлэлцүүлэг зохион байгуулна. • Туршилтын сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалт болон суралцахуйд нь дэмжлэг үзүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангана. (шатны бариул, хэрэглэгдэхүүн)

	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлтэй, хоцрогдолтой хүүхдэд хичээлийн бус цагаар хүүхэд нэг бүрийн бодит байдалд тохирсон дэмжлэгийг үзүүлэх “Хүүхэд хөгжлийн төв” байгуулж туршина.
Бусад	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулна.(сонинд нийтлэх, мэдээлэл сурталчилгааны видео, Facebook, цахим хуудсаар мэдээлэл түгээх, үйл ажиллагаагаа танилцуулах зэрэг)



Төслийн цахим хуудас

Япон хэл дээр : <https://www.jica.go.jp/project/mongolia/013/index.html>

Монгол хэл дээр : <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/013/index.html>

Англи хэл дээр : <https://www.jica.go.jp/project/english/mongolia/013/index.html>

Төслийн Facebook (Япон • Монгол) : <https://www.facebook.com/jicastart/>

1.3 JICA өвсний үндэс техникийн хамтын ажиллагаа: Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээ, боловсролыг дэмжих болон асран хамгаалагчдыг хөгжүүлэх төсөл

“Нинжин” төрийн бус байгууллага нь 2016 оны 9 дүгээр сараас Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-н Өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд “Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эцэг эх мэргэжилтнийг чадавхжуулах төсөл”-ийг эхлүүлсэн билээ.

Өрхийн эмч, хөдөлгөөн засалч, ахуй засалч, сувилахуйн сургуулийн багш, цэцэрлэгийн багш (2018 оны 09 дүгээр сараас) болон санхүү хариуцсан ажилтанд эцэг эхчүүдэд хэрхэн хүүхэдтэйгээ харьцах тухай зааж, бодит амьдрал дээр хэрэгжүүлэх тал дээр анхаарал хандуулан ирсэн. Мөн Монголын хөдөлгөөн засалч нартай хамтран 2 загвар төвийг байгуулах замаар дэмжих тогтолцоог бий болгохоор зорин ажиллаж байна. 2019 оны 08 дугаар сард төсөл дуусах үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн

төвийн загварыг холбогдох яам, газруудад танилцуулах юм.

Тус төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах замаар нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэхийг зорилго болгон ажиллаж байна.

Эхний жилд “Нинжин” төрийн бус байгууллагын баг ирээд тус тусдаа тархины саажилттай хүүхдийн асран хамгаалагчдад хөдөлгөөн заслын талаар зааварчилгаа өгөн, буцаад төв дээр цуглан хамтдаа хийж болох дасгалыг эцэг эхтэй хамт хийх аргыг зааж байсан. Боловсролын тухайд тооны бодлогуудыг тус тусынх нь төвшинд тааруулан бэлдэж, 2 төв дээр нийлээд 100 ширхэг зурагт номыг байршуулан уншуулж эхэлсэн.

Эцэг эх нь хоёулаа ажилладаг зэрэг олон шалтгааны улмаас гэртээ тогтмол дасгал, хөдөлгөөн зэрэг хөгжүүлэлт хийх нь хүндрэлтэй байсан тул 2017 оны 10 дугаар сараас эхлэн 7 хоног болгоны бямба гарагт эцэг эх болон хүүхдүүд төв дээр цуглах “Өвсний үндэс төслийн өдөрлөг” болгосон.

- Өвсний үндэс төслийн үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүдийн 80 хувь нь энгийн сургууль болон тусгай сургуульд суралцаж байна.
- 2018 оны 09 дүгээр сараас цэцэрлэгийн багш нар оролцон 2 төв дээр сургалт зохион байгуулж гэртээ ашиглах боломжтой сургалтын материал танилцуулсан.

2. Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”

1. Үндсэн мэдээлэл:

Төслийн хугацаа: 2018.04.30-2022.10.31

Хэрэгжүүлэгч байгууллага: Азийн хөгжлийн банк

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Төслийн хамрах хүрээ: Улаанбаатар хот, 6 аймаг

2. Ерөнхий тойм

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийг Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг /2001 он/, 2014-2020 оны Нийгмийн хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулсан болно. Төсөл нь нийгмийн хамгийн эмзэг бүлгийн гишүүдийг хамгаалахын тулд нийгмийн хамгааллын шинэчлэлд анхаарал хандуулахыг уриалсан 2020 он хүртэлх Стратегийн дунд хугацааны үнэлгээг дэмжсэн.

Түүнчлэн энэхүү төсөл нь хүн бүрийг зохистой амьдрах нөхцөлөөр хангахад нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоог бүрдүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихэд чиглэсэн Азийн хөгжлийн банкны дунд хугацааны Түншлэлийн Стратеги (2014-2026)-ийн баримт бичигтэй нийцэж байгаа болно. Улмаар энэхүү төсөл нь 2030 он хүртэлх Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх юм.

- Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх үйлчилгээг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлж эхэллээ. Тус төслийн хүрээнд:

- 6 аймагт /Ховд, Хөвсгөл, Дорнод, Дундговь, Архангай, Дархан/ бүсчилсэн байдлаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийг байгуулна. Тус төвүүдээр 4 жилийн хугацаанд 90,000 хүүхдийг онишилгоонд хамруулж, 5535 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрт хөгжүүлэх үйлчилгээнд хамрагдана.

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт, үйлчилгээ, бизнес инкубаторын төвийг байгуулна. Тус төвөөр үйлчлүүлснээр 5000 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажлын байртай болно.

- Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний болон орчны хүртээмжийг сайжруулах хүрээнд ажиллах зөвлөх фирмийг сонгон шалгаруулж, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх загварыг институтчилэх, эрт илрүүлэх ур чадварыг хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлийг тогтоох эмнэлгийн аргачлалаас нийгмийн загварчлалд шилжихэд дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг барьж байгуулах ажлын хүрээнд зөвлөх компанийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийг боловсруулж хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн хандлагыг сайжруулах чиглэлээр олон нийттэй харилцах ажлыг эхлүүлж, зохион байгуулна.
- Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын чадавхийг сайжруулах, мөн салбар зөвлөлийн чадавхийг сайжруулах сургалт, семинарыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

Төслийн үр нөлөө, үр дүн, бүрэлдэхүүн хэсгүүд

Төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд адил тэгш үр нөлөө үзүүлнэ. Төслөөс

гарах үр дүн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд нийгмийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршиж байна.

Энэ төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, бие даан нийгмийн амьдралд саадгүй, чөлөөтэй оролцох боломжийг дээшлүүлэх замаар тэдний нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенц, Инчеоны стратегийг хэрэгжүүлэх, Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. Төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэдийн амьдралын мөчлөгт чиглэсэн үйлчилгээ, дэмжлэгийн эрэлт хэрэгцээг хангах зорилго бүхий дараах 5 бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

- (i) **Бүрэлдэхүүн 1: Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх бэхжиж, институтчилэгдэнэ.** Төслийн хүрээнд (а) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санаачилсан хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх загварыг институтчилнэ, (b) эрт илрүүлэх ур чадварыг хөгжүүлснээр хөгжлийн бэрхшээлийг тогтоох эмнэлгийн аргачлалаас нийгмийн загварчлалд шилжихэд дэмжлэг үзүүлнэ. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлснээр сөрөг үр нөлөөг бууруулах, боломжийн хэрээр урьдчилан сэргийлж чадсанаар боловсрол, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн амьдралд оролцох чадварыг нэмэгдүүлэх боломжтой юм.
- (ii) **Бүрэлдэхүүн 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмж сайжирна.** Энэхүү төслийн хүрээнд (а) эцэг эх-хүүхэд-багш гэсэн боловсролын загварыг аль болох бага наснаас эхлэн хэрэгжүүлнэ; (б) зургаан аймагт загвар бүхий Хөгжлийн төвүүдийг байгуулна; (в) хөдөлгөөний болон хэл ярианы засалч, хөдөлгөөн засалч, хиймэл эрхтний техникч, нийгмийн ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр гаргах; (г) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих нийгмийн ажилтнуудыг чадавхижуулах; (д) хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дуудлагын шууд утас нэвтрүүлэх.
- (iii) **Бүрэлдэхүүн 3: Орчны хүртээмж сайжирна.** Энэ нь (а) орчны (дэд бүтэц, тээвэр, мэдээлэл) хүртээмжийн хэм хэмжээнүүдтэй холбогдсон эрх зүйн орчныг боловсруулах, дагаж мөрдүүлэх асуудлыг хариуцсан байгууллага болон шийдвэр гаргагч нарын чадавхийг дээшлүүлэх; (б) дагаж мөрдүүлэх механизмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах; болон (в) чанартай хиймэл эрхтний төхөөрөмж, туслах технологийн хүртээмжийг, тэр дундаа аймгуудад хангах юм. Энэ үр дүнд хүрэхийн тулд орчны саадыг бууруулах, мэдээлэл, нийтийн барилга

байгууламж, тээврийн хэрэгслийн хүртээмжийг хангахад чиглэсэн дүрэм журмуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах юм. Туслах хэрэгсэл, үйлчилгээний хүртээмжийг сайжруулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд идэвхтэй хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж, тэдэнд тулгарч буй саад бэрхшээлийг бууруулна.

(iv) **Бүрэлдэхүүн 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил, хөдөлмөр эрхлэлт сайжирна.** Энэхүү зорилтын хүрээнд (а) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тодорхой аж үйлдвэрийн чиглэлээр ур чадварыг нь дээшлүүлэх, ажил зуучлалыг сайжруулах загварыг бий болгох, (б) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд ажлын байр, хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох замаар хөгжлийн бэрхшээлийг хамруулсан бизнесийг хөгжүүлэх, (в) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг зохицуулсан дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавихад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийнх нь оролцоог нэмэгдүүлэх юм. Эдгээр арга хэмжээ нь төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, үйлчилгээг илүү үр дүнтэй болгох бодлого баримталж, хөдөлмөр эрхлэх (кэйс менежмент, ажил мэргэжлийн зөвлөгөө) боломжийг бүрдүүлэх; хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил олгогч, төрийн хөдөлмөр эрхлэлтийн албадад үйлчилгээ үзүүлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийн төв (дэд бүтэц, тоног төхөөрөмж, сургалт, чадавх бэхжүүлэх арга хэмжээ гм.)-ийг Улаанбаатар хотод ажиллуулж, үйл ажиллагааг нь дэмжих; түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн квоттой холбогдсон эрх зүйн заалтуудыг дагаж мөрдүүлэхэд ажил олгогч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх.¹

(v) **Бүрэлдэхүүн 5: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийг боловсруулж хэрэгжүүлнэ.** Энэхүү бүрэлдэхүүн хэсэг (а) хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлагыг өөрчлөх, (б) үйлчилгээ, тоног төхөөрөмжийн хүртээмжийг сайжруулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх халамжийн тогтолцоог шинэчлэх, (в) үндэсний хөтөлбөрийг стратегийн хувьд эргэн харах, (г) Олон улсын үйл хөдлөлийн ангиллыг хөгжлийн бэрхшээлийн эрэлт хэрэгцээ, боломжит нөөцөд нийцүүлэн нэвтрүүлэх, (д) Үндэсний статистикийн хорооны тоо мэдээг хөгжлийн бэрхшээлтэй холбогдсон мэдээллийн эрэлттэй нийцүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлагыг аажмаар өөрчлөхөд чиглэсэн олон нийтийн компанит ажил явуулах, Олон улсын үйл хөдлөлийн ангиллыг нэвтрүүлснээр хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг сайжруулах болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй саад бэрхшээлүүдийн талаарх статистик тоо мэдээг сайжруулах замаар нийгэмд хамруулан хөгжүүлэхэд шууд бус оролцоог хангаж ажиллана.

¹ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, нөөцийн төвийг барих заримт зардлыг Итгэлцлийн сангийн буцалтгүй тусламжаас санхүүжүүлэх юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын чадавхийг сайжруулах, мөн салбар зөвлөлийн чадавхийг сайжруулах сургалт, семинарыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

3. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслийн талаар

А. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв төсөл”

БНХАУ-ын тусламжаар Монгол Улсад баригдаж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийн төсөл нь БНХАУ-аас Монгол Улсад үзүүлж байгаа тусламжийн ажлуудын хамгийн том хүмүүнлэгийн төсөл юм.

Төвийн барилгын төслийг БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар бүтээн байгуулж, БНХАУ-ын “Ай Пи Пи Ар олон улсын Инженеринг” ХХК-аас төслийн зураг төслийг боловсруулах болон удирдан зохион байгуулах ажлыг гүйцэтгэж, барилга угсралтын ажлыг БНХАУ-ын “СТСЕ групп” ХХК гүйцэтгэсэн болно.

Тус барилга ашиглалтанд орсноор Монгол Улсын хамгийн том, орчин үеийн, бүрэн тоноглогдсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээ сувилгаа, сэргээн заслын төв болох бөгөөд, Монгол Улсын эмчилгээний системийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн түвшинг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

Тус төслийн барилга нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын баруун хэсэгт, Сонгсголонгийн зам дагуу байрлах ба урд талаараа Туул гол, Богд уулын дархан цаазат бүс оршдог. Төслийн нийт ашиглалтын талбайн хэмжээ 20,000 м². Төслийн барилга нь 250 ортой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв бөгөөд өдөрт 250 өвчтөнийг хүлээн авах хүчин чадалтай, барилга байгууламжийн нийт талбай 14990м². Барилга нь хүлээн авах тасаг, сэргээн засах эмчилгээний тасаг, захиргааны оффис болон сэргээн засах сургалтын төв, хэвтэн эмчлүүлэх тасаг, арын албаны үйлчилгээ зэрэг хэсгээс бүрдэнэ.

Түүнчлэн төслийн хэрэгжилтийн явцад, БНХАУ-ын гадаад тусламжийн бодлогыг хэрэгжүүлж, Монгол Улсад хамгийн сайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах үйлчилгээний төвийг байгуулахаар зорилт тавин ажиллаж, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж, Монгол Улсын барилгачдын ур чадварыг нэмэгдүүлэх тал дээр хичээн дэмжин ажиллаж, мөн орон нутгаас их хэмжээний бараа материал болон бүтээгдэхүүн худалдан авалт хийж, Монгол Улсын зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулсан.

Төслийн гүйцэтгэлийн хугацаанд дунджаар 120 монгол ажилчин ажиллаж, ажлын

ачаалал хамгийн их үедээ 260 гаруй монгол ажилчин төсөл дээр ажилласан байна. Өрлөгийн ажил, шавардлага, дээвэр, агааржуулалтын хоолой угсрах, дулаан хангамж, тасалгааны цахилгаан холболт, шалны цутгалт зэрэг ажлуудыг Монгол Улсын аж ахуйн нэгж гүйцэтгэж, олон тооны ажилчдыг ажлын байраар хангасан.

БНХАУ-ын буцалтгүй тусламжаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийг барьж 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Засгийн газар төвийн барилгыг хүлээн авлаа.

Б. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолборын төсөл

Мөн БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 20.4 сая ам долларын өртөгтэй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолборын ордон” барих ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Тус спорт цогцолбор ордон нь нийтдээ 19,567.0м² талбай бүхий зоорьтой 7 давхар барилга бөгөөд зочид буудал, 200м тойрог бүхий манеж, гадна талдаа 400м тартан зам, 200 ортой тамирчдын байрлах байр, 150 хүн зэрэг хооллох хоолны газар, хурлын танхим, заалны тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн явуулах спорт заал, фитнес заал, жудо бөх, хүндийн өргөлт, таеквандо, сагсан бөмбөг, суугаа волейбол, ширээний теннис, хөнгөн атлетик, байт харваа, хонхот бөмбөг, буудлага зэрэг пара спортын 10 төрөлд зэрэг хичээллэх боломжтой бэлтгэлийн заалтай олон улсын стандартад нийцсэн тусгай тоноглол бүхий ордон байна.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын

адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;

4.1.2. “хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.3. “тохирох хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.4. “түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг;

4.1.5. “хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг;

4.1.6. “боломжит дээд хэмжээ” гэж тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч алдагдсан чадварыг нь сэргээж болох дээд хэмжээ;

4.1.7. “урьдчилан сэргийлэх” гэж иргэн, хамт олны оролцоотойгоор өвчин эмгэг, осол гэмтлийн эрсдэлээс хамаарах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, өвчин эмгэгийг эрт илрүүлж эмчлүүлэх, тэдгээрээс үүдэн гарах эрүүл мэндийн болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах үйл ажиллагааг;

4.1.8. “туслах хэрэгсэл” гэж биеийн бүтцийн гажиг, үйл ажиллагааны алдагдлыг орлох, засах, хамгаалах, дэмжих, гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;

4.1.9. “асаргаа сувилгааны хэрэгсэл” гэж асруулж байгаа хүний эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах, асарч байгаа хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;

4.1.10. “ариун цэвэр-эрүүл ахуйн материал” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын эрүүл ахуйн шаардлагыг хангах, зайлшгүй хэрэгцээтэй материал хэрэгслийг;

4.1.11. “бие даан амьдрах эрх” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах, сонголт хийх, оролцох боломжийг;

4.1.12.“хөтөч нохой” гэж хараагүй хүн тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах зорилгоор тусгайлан сургаж, бэлтгэсэн нохойг;

4.1.13.“дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилдэг хүнийг.

5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим

5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараахь зарчмыг баримтална:

5.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих;

5.1.2. хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх;

5.1.3. сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.4. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх;

5.1.5. хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх;

5.1.6. хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАРИЛЦААНД ТЭГШ ОРОЛЦОХ ЭРХ

6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах

6.1. Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

6.2. Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын

адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.

6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.3.1.нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй байх;

6.3.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх;

6.3.3.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандах;

6.3.4.хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгааны улмаас зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

6.3.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрхийг өөрийн нь зөвшөөрөлгүйгээр хязгаарлах;

6.3.6.төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх.

6.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.4.1.ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ажилд авахаас татгалзах;

6.4.2.хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлах;

6.4.3.байгууллага, аж ахуйн нэгж нь ажиллагсадыг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам, удирдлагын арга барилыг хэрэглэх, ашиглах;

6.4.4.гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүнийг ажилд авахаас татгалзах, чөлөөлөх, бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарлах;

6.4.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдлэг ур чадвар, онцлогт тохирсон ажлын байрыг зохион байгуулахаас татгалзах, цалин хөлсийг ялгавартай тогтоох;

6.4.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон ажлын байрны тохирох хэрэглэгдэхүүн бий болгохгүй байх.

6.5.Дараахь үйлдлийг бусад ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.5.1.хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх, хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд суурилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;

6.5.2.гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх;

6.5.3.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг үр хүүхдээ асрамжиндаа авах эрхийг хязгаарлах.

6.6.Төрөөс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс нь хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7.Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

6.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралд тэгш оролцох эрхийг нь бодитой хангах зорилгоор онцлогт нь тохируулан авч хэрэгжүүлж байгаа тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх

7.1.Гэр бүл болон нийгмийн бүхий л хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

7.1.2.Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зөв ойлголтыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого хэрэгжүүлэх;

7.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх эерэг хандлагыг төлөвшүүлэх асуудлыг бүх шатны боловсролын байгууллагын сурах бичигт тусгайлан тусгаж, сургалт, хичээлийн агуулгаар дамжуулан хэрэгжүүлэх;

7.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлд өгөх, сургалт, сурталчилгаа явуулах арга хэмжээг зохион байгуулах;

7.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэх, түүнд чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, гэр бүл, иргэдийн санал санаачлагыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаархи эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгыг агуулсан арга хэмжээг зохион байгуулан холбогдох зардлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган шийдвэрлэх.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын оролцоог хангана.

7.3.Энэ хуулийн 7.1.4-т заасан арга хэмжээг зохион байгуулах ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалдаг байгууллагатай гэрээгээр гүйцэтгүүлж болох ба холбогдох зардлыг Нийгмийн халамжийн сангаас гаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ АЖИЛЛАЖ АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

8 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ

8.1.Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

8.2.Нийтийн тээвэр, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээ, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, хиймэл эрхтэн, туслах болон асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, хэрэгсэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.

8.3.Төрийн байгууллага нь нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, шаардлагатай стандарт, удирдамжийн баримт бичгийг боловсруулах, хяналт шалгалт хийх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, судалгаа шинжилгээ хийх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба холбогдох зардлыг улсын төсөвт тусгана.

8.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулах, түүнд мэдээлэл харилцааны технологийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, хувцас, орон байр, ахуйн хэрэгслээр хангах арга хэмжээг авч, зардлыг барилга, зам, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл. Орон сууц, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх

9.1.Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах нөхцөлийг энэ хууль, хот байгуулалтын болон барилгын тухай хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх ажлыг иргэн, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.

9.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн авто болон явган хүний зам, замын байгууламжийн заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилга, зам, тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.

